

Оросын Холбооны Улсын Хөдөө аж ахуйн яамны
2015 оны 4-р сарын 6-ны өдрийн №43-у тоот
тушаалаар батлав

ХОЛБООНЫ УЛСЫН ТӨСӨВТ ДЭЭД БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА
“КРАСНОЯРСКИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ”
ДҮРЭМ

Красноярск хот

2015 он




UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Холбооны улсын төсвийн мэргэжлийн дээд боловсролын байгууллага болох "Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль", цаашид "Их сургууль" гэх, нь ЗХУ-ын Сайд нарын зөвлөлийн 1952 оны 4-р сарын 29-ний өдрийн "Красноярскийн хязгаарын хөдөө аж ахуйг дэмжих арга хэмжээнүүдийн тухай" №2062 тоот тогтоол болон Красноярскийн хөдөө аж ахуйн дээд сургууль нэрээр "Красноярск хотод Красноярскийн хөдөө аж ахуйн дээд сургууль байгуулах тухай" ЗХУ-ын Дээд боловсролын сайдын 1952 оны 5-р сарын 17-ны өдрийн №799 тоот тогтоолын дагуу үүсгэн байгуулагдсан бөгөөд улмаар нэрийг нь: ЗХУ-ын Сайд нарын зөвлөлийн Хүнс, худалдан авалтын улсын комиссын 1991 оны 1-р сарын 11-ний өдрийн "Хөдөө аж ахуйн улсын их сургуулиудыг зохион байгуулах тухай" №5 тоот тушаалаар - Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль, ОХУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны "Красноярскийн хязгаар дахь боловсролын улсын байгууллага Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургуулийн тухай" 1997 оны 3-р сарын 17-ны өдрийн №118 тоот тушаалаар – улсын боловсролын байгууллага Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль болгон өөрчилж, энэ нэрээр Красноярск хотын төвийн районы захиргаа 1997 оны 11-р сарын 28-ны өдөр бүртгэн авч (улсын бүртгэлийн №15828 тоот гэрчилгээ, Сери 6-А), ОХУ-ын Татварын яамны Красноярскийн хязгаарын Красноярск хотын төвийн районыг хариуцсан алба Хуулийн этгээдийн улсын нэгдсэн жагсаалтад улсын ерөнхий бүртгэлийн 1022402651006 дугаарт бүртгэн авсан (2002 оны 7-р сарын 1-ний өдрөөс өмнө бүртгэгдсэн хуулийн этгээдийн тухай Хуулийн этгээдийн улсын нэгдсэн бүртгэлд 2002 оны 10-р сарын 21-ний өдөр хийгдсэн бичилтийг гэрчлэх сери 24, №000842972 тоот Гэрчилгээ), Оросын Холбооны Улсын Хөдөө аж ахуйн яамны 2002 оны 3-р сарын 12-ны өдрийн "Холбооны мэргэжлийн дээд боловсролын улсын боловсролын байгууллага "Красноярскийн хязгаар дахь Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургуулийн" тухай" №232 тоот тушаалаар Холбооны мэргэжлийн дээд боловсролын улсын боловсролын байгууллага - Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль болгон өөрчилж, улмаар Холбооны мэргэжлийн дээд боловсролын улсын боловсролын байгууллага "Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль" болон өөрчлөгдсөнийг улсын бүртгэлд 2022402651016 дугаарт бүртгэсэн (хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулж буй өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж авсан тухай 2002 оны 10-р сарын 21-ний өдрийн сери 24, №000842973 тоот Гэрчилгээ), улсын бүртгэлийн 2032402973271 ерөнхий дугаарт бүртгэгдсэн өөрчлөлтүүдийн хамт (хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулж буй өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэсэн тухай 2003 оны 11-р сарын 10-ны өдрийн сери 24, №000967917 тоот Гэрчилгээ), Холбооны татварын албаны Красноярскийн хязгаарын Красноярск хотын төвийн районыг хариуцсан газрын улсын бүртгэлийн 2052466004303 дугаарт бүртгэгдсэн өөрчлөлтүүдийн хамт (хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулж буй өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж авсан тухай 2005 оны 1-р сарын 20-ны өдрийн сери 24, №000379962 тоот Гэрчилгээ), Холбооны татварын албаны Красноярскийн хязгаар хариуцсан дүүрэг дундын 23-р хэлтэс улсын бүртгэлд 2062466273990 дугаарт бүртгэн авсан өөрчлөлтүүдийн хамт (хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулж буй өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж авсан тухай 2006 оны 12-р сарын 25-ны өдрийн сери 24, №005591987 тоот Гэрчилгээ), Оросын Холбооны Улсын Засгийн газрын 2007 оны 3-р сарын 15-ны өдрийн №287-р тоот Захирамжийн дагуу Оросын Холбооны Улсын Хөдөө аж ахуйн яамны 2007 оны 4-р сарын 27-ны өдрийн "ХМДБУББ "Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль" болон холбооны боловсролын улсын байгууллагуудыг өөрчлөн байгуулах тухай" №222 тоот тушаалаар мэргэжлийн нэмэлт боловсрол олгох холбооны улсын



Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

боловсролын байгууллагууд болох “Красноярскийн Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн цогцолборын ажилтны мэргэжил дээшлүүлэх институт” болон “Бүгд Найрамдах Тыва улсын Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн цогцолборын ажилтан бэлтгэх, давтан сургах болон мэргэжил дээшлүүлэх сургалтын төвийг” тус Их сургуультай нэгтгэх замаар өөрчлөн байгуулагдаж, тэдгээрийн эрх үүргүүдийн хууль ёсны залгамжлагч болсон; Холбооны татварын албаны Красноярскийн хязгаар хариуцсан дүүрэг дундын 23-р хэлтэс улсын бүртгэлд 2082468042820 дугаарт бүртгэн авсан өөрчлөлтүүдийн хамт (хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулж буй өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж авсан тухай 2008 оны 1-р сарын 30-ны өдрийн сери 24, №004509163 тоот Гэрчилгээ); Оросын Холбооны Улсын Хөдөө аж ахуйн яамны 2011 оны 5-р сарын 23-ны өдрийн “ХМДБУББ болон түүний салбар сургуулиудын нэрийг өөрчлөх тухай” №132 тоот тушаалаар холбооны мэргэжлийн дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага “Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль” болж өөрчлөгдсөн; Холбооны татварын албаны Красноярскийн хязгаар хариуцсан дүүрэг дундын 23-р хэлтэс улсын бүртгэлд 2112468498118 дугаарт бүртгэн авсан өөрчлөлтүүдийн хамт (хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулж буй өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж авсан тухай 2011 оны 11-р сарын 21-ны өдрийн сери 24, №005740027 тоот Гэрчилгээ); Оросын Холбооны Улсын Хөдөө аж ахуйн яамны 2014 оны 9-р сарын 15-ны өдрийн “ХМДБУТББ болон түүний салбар сургуулиудын нэрийг өөрчлөх тухай” №357 тоот тушаалаар холбооны дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага “Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль” болсон байна.

Тус их сургууль нь холбооны дээд боловсролын улсын боловсролын байгууллага болно.

- 1.2. Оросын Холбооны Улсын Засгийн газрын 2008 оны 6-р сарын 12-ны өдрийн 450 тоот тогтоолоор батлагдсан Оросын Холбооны Улсын Хөдөө аж ахуйн яамны тухай журам болон Оросын Холбооны Улсын Засгийн газрын 2006 оны 7-р сарын 22-ны өдрийн 1041-р тоот захирамжийг үндэслэн тус Их сургууль нь Оросын Холбооны Улсын Хөдөө аж ахуйн яамны (цаашид “ОХУ-ын ХААЯ” гэх) мэдэлд байна.

ОХУ-ын ХААЯ нь Их сургуулийг үүсгэн байгуулагчийн (цаашид “Үүсгэн байгуулагч” гэх) бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд Оросын Холбооны Улсын Төсвийн тухай хуулийн дагуу холбооны төсвийн хөрөнгийн ерөнхий захиран зарцуулагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж, үүний дотор улсын даалгаврыг биелүүлэхэд гарах нормативын зардлуудыг нөхөхөд зориулагдсан улсын тэтгэмж тусламж, түүнчлэн бусад зорилгоор олгогдох тусламж тэтгэмжүүд, төсвийн хөрөнгө оруулалт болон хувь хүмүүсийн өмнө хүлээсэн олон нийтийн үүргийн биелэлтэд зориулагдсан төсвийн хөрөнгийг Их сургуульд хүргэж, холбооны төсвийн хөрөнгийн зориулалтын дагуу ашиглагдаж байгаа эсэх, тайлан гаргалт, төрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон үүрэг даалгаврын биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.

Үүсгэн байгуулагчийн баршил: 107139, Москва хот, Орликов переул, 1/11 тоот.

- 1.3. Их сургуулийн албан ёсны нэр:

Бүтнээр:

Орос хэлээр - холбооны дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага “Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль”;



UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

Англи хэлээ – Federal State Budgetary Educational Institution of Higher Education “Krasnoyarsk State Agrarian University”;

Товчилсон нэр:

Орос хэлээр – ХДБУТББ Красноярскийн ХААУИС

Англи хэлээр – FSBEI HE KrasSAU

- 1.4. Их сургуулийн байрлах газар: 660049, Красноярскийн хязгаар, Красноярск хот, Энхтайвны өргөн чөлөө, 90

Шуудангийн хаяг: Энхтайвны өргөн чөлөө, 90, Красноярск хот, Красноярскийн хязгаар, 660049

- 1.5. Их сургууль нь хуулийн этгээд байх бөгөөд Оросын Холбооны Улсын Үндсэн хууль, Оросын Холбооны Улсын Иргэний хууль, Оросын Холбооны Улсын Төсвийн тухай хууль, Оросын Холбооны Улсын Татварын тухай хууль, холбооны хуулиуд, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч, Оросын Холбооны Улсын Засгийн газар, холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагуудаас гаргасан актууд, бусад актууд болон энэхүү Дүрмийн дагуу өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Их сургууль нь холбооны дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага байх бөгөөд улсын даалгаврыг биелүүлэхэд гарах нормативын зардлуудыг нөхөхөд зориулагдсан улсын тэтгэмж тусламжийн хөрөнгө, мөн түүнчлэн орлого бүхий үйл ажиллагаанаас олсон хөрөнгө болон түр хугацаагаар эзэмшиж буй хөрөнгөтэй хийх гүйлгээг тооцоход зориулагдсан Оросын Холбооны Улсын валютын харилцах данс, хувь хүмүүсийн өмнө хүлээсэн олон нийтийн үүргийн биелэлтэд зориулагдсан хөрөнгөтэй хийх гүйлгээг тооцоход зориулагдсан харилцах данс болон Холбооны санхүүгийн бүс нутгийн байгууллагуудад зохих журмын дагуу нээсэн бусад данснуудтай байна.

Их сургууль нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу зээлийн байгууллагуудад нээсэн гадаад валютын хөрөнгийг тооцоход зориулагдсан данстай байх эрхтэй бөгөөд үйл ажиллагаандаа захиран зарцуулах эрх бүхий тусдаа хөрөнгөтэй, тусдаа баланстай, Оросын Холбооны Улсын төрийн сүлд бүхий өөрийн бүтэн нэртэй тамга, тэмдэг, бланк, өөрийн гэсэн бэлгэдэлтэй байна. Их сургууль нь өөрийн нэрийн өмнөөс эд хөрөнгийн болон хувийн эд хөрөнгийн эрхүүдийг олж авах болон хэрэгжүүлэх, хариуцлага хүлээж, шүүхэд нэхэмжлэгч болон хариуцагч байж болно.

- 1.6. Их сургууль нь өөрийн үйл ажиллагааны үндсэн зорилгын хүрээнд дээд боловсролын хөтөлбөрүүдийн дагуу боловсролын үйл ажиллагаа болон шинжлэх ухааны үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Их сургуулийн үндсэн зорилтууд нь:

- Нийгмийн болоод улс орны эрэлт хэрэгцээнд нийцүүлэн нийгмийн тустай үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдээр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх явдлыг хангах, хувь хүний оюуны, соёлын болон ёс суртахууны хөгжил, боловсрол, шинжлэх ухаан-сурган хүмүүжүүлэх ажлыг гүйнзгийрүүлэх болон өргөжүүлэх хэрэгцээ шаардлагуудыг хангах.
- Боловсролын үндсэн хөтөлбөрүүд болон янз бүрийн нэмэлт боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, боловсролын хэд хэдэн хөтөлбөрийг зэрэг эзэмших боломж олгох замаар, мөн түүнчлэн боловсрол олж авах үйл



UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

ажиллагаан дахь одоогийн боловсрол, мэргэшил, дадлага туршлагыг харгалзан боловсролын үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх.

- Суралцагчдын мэдлэг, чадвар, дадал олж авах, ажлын туршлагатай болж, авьяас чадвараа хөгжүүлэх, мэдлэгээ өдөр тутмын амьдралд хэрэглэх туршлагатай болох үйл ажиллагааг зохион байгуулж, суралцагчдад бүхий л амьдралынхаа туршид боловсрол олж авах сэдэлийг бий болгох.
- Шинжлэх ухааны судалгааг боловсон хүчнээр хангах, дээд боловсролын хөтөлбөрүүдийн дагуу суралцагчдын бэлтгэлийн чанарыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх ажилтнуудын удирдлага доор шинжилгээ судалгааны ажил явуулахад суралцагчдыг татан оролцуулах, боловсролын үйл ажиллагаанд шинэ мэдлэг болон шинжлэх ухаан техникийн ололтуудыг ашиглах зорилгоор дээд боловсрол дахь боловсролын болон шинжлэх ухааны (эрдэм шинжилгээний) үйл ажиллагааны нэгдмэл байдлыг (интеграцыг) хангах.
- Эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх ажилтнууд болон суралцагчдын тулгамдаж буй асуудлууд, үүний дотор боловсролын асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн шинжилгээ судалгаануудын тусламжтайгаар шинжлэх ухаан техникийг хөгжүүлэх, шинжлэх ухааны сургуулиудыг хөгжүүлэх, судалгааны үр дүнгүүдийг боловсролын үйл явц хийгээд инновацын үйл ажиллагаанд ашиглах.
- Суралцагчдад хүн, гэр бүл, нийгэм болоод улс орны эрх ашгийн үүднээс нийгэм-соёлын, оюун санаа-ёс суртахууны үнэт зүйлс болон нийгэмд бие авч явах тогтсон хэм хэмжээнүүдийн үндсэн дээр хувь хүний хувьд төлөвшин, өөрийгөө тодорхойлж, нийгэмших нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн хүмүүжил олгох.
- Суралцагчдыг эх оронч үзэл, ард түмэн, үндэсний уламжлал болон оюуны өв сангаа хайрлаж хүндлэх, Их сургуулийн нэр хүндийг дээдлэх сэтгэлээр хүмүүжүүлэх.
- Суралцагчдын иргэний байр суурийг төлөвшүүлж, хариуцлага, бие даасан, бүтээлч идэвхийг нь хөгжүүлэх.
- Мэргэжилтнүүд, удирдах болон эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх ажилтнуудыг бэлтгэх, давтан бэлтгэх болон мэргэжлийн ур чадварыг нь дээшлүүлэх.
- Нийгмийн ёс суртахууны, соёлын болон шинжлэх ухааны үнэт зүйлсийг хадгалж үлдэх болон улам бүр нэмэгдүүлэх.
- Хүн амын дунд мэдлэг боловсролыг түгээж, тэдний боловсролын болоод соёлын түвшинг дээшлүүлэх.

Боловсролын хүмүүнлэг шинж чанараас, нийт хүн төрөлхтний үнэт зүйлсийг урьтал болсгосноор урган гарч буй хүмүүжлийн зорилтууд нь суралцагчид болон ажилтнуудын хамтарсан боловсролын, эрдэм шинжилгээний, үйлдвэрлэлийн, нийгмийн болоод бусад үйл ажиллагаагаар хэрэгжих юм.

- 1.7. Өөрт нь хүлээлгэсэн үүргүүдийг биелүүлэх үүднээс Их сургууль нь дараах үндсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ:




UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Боловсролын үйл ажиллагаа эрхлэх эрхийн тусгай зөвшөөрлийн дагуу дараах боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх:
 - а) дээд боловсролын мэргэжлийн үндсэн боловсролын хөтөлбөрүүд (бакалаврын хөтөлбөрүүд),
 - б) дээд боловсролын мэргэжлийн үндсэн боловсролын хөтөлбөрүүд (мэргэшүүлэх хөтөлбөрүүд),
 - в) дээд боловсролын мэргэжлийн үндсэн боловсролын хөтөлбөрүүд (магистрын хөтөлбөрүүд),
 - г) дээд боловсролын мэргэжлийн үндсэн боловсролын хөтөлбөрүүд (аспирантурт эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх боловсон хүчин бэлтгэх хөтөлбөрүүд),
 - д) мэргэжлийн тусгай дунд боловсролын үндсэн мэргэжлийн боловсролын хөтөлбөрүүд (дунд шатны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх хөтөлбөрүүд).
 - Шинжлэх ухааны боловсон хүчин бэлтгэх (докторантурт)
 - Хавсрага эрдэм шинжилгээ судалгааны ажлууд явуулах, шинжлэх ухааны туршилтын ажлууд хийж гүйцэтгэх.
- 1.8. Их сургууль нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу дараах төрлийн ашиг орлого бүхий үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх эрхтэй:
- Ерөнхий боловсролын үндсэн хөтөлбөрүүд, мэргэжлийн тусгай дунд боловсролын сургалтын хөтөлбөрүүд, дээд боловсролын сургалтын хөтөлбөрүүд – бакалаврын хөтөлбөр, мэргэшүүлэх хөтөлбөр, магистрын хөтөлбөр, аспирантурт эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх боловсон хүчин бэлтгэх хөтөлбөр, мэргэжлийн сургалтын хөтөлбөр, ерөнхий боловсролын нэмэлт хөтөлбөрүүд, мэргэжлийн нэмэлт хөтөлбөрүүдээр боловсролын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөөр тогтоосон хүрээнд холбооны төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх суралцагч хүлээн авах улсын даалгавраас (хяналтын тооноос) давсан, үүний дотор улсын даалгавар юм уу зардал нөхөх тэтгэмж олгох тухай гэрээнд заагаагүй боловсролын үйлчилгээг үзүүлэх,
 - Боловсролын зохих хөтөлбөрүүд болон холбооны боловсролын улсын стандартуудад заагаагүй, үүний дотор бэлтгэл салбарууд, курсууд болон дээд сургуулийн өмнөх бэлтгэлийн төвүүдэд боловсролын нэмэлт төлбөртэй үйлчилгээ үзүүлэх,
 - Хуулийн этгээдүүд болон (буюу) хувь хүмүүстэй байгуулсан гэрээний дагуу Холбооны төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх шинжлэх ухаан-техникийн хөтөлбөрүүдэд багтаагүй дүн шинжилгээ, эрдэм шинжилгээний болон туршилт зохион бүтээх суурь болон хавсарга шинжилгээ судалгааны ажлуудыг гүйцэтгэх, мөн түүнчлэн тэдгээртэй холбогдсон эрхүүдийг хэрэгжүүлэх,
 - Ургамал судлалын салбарт селекцийн ба үр тариа ургуулах ажлууд болон мал аж ахуйн салбарт үүлдэр селекцийн ажлууд явуулах,



UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Онцгой эрхүүдийг нь Их сургууль эзэмших оюуны бүтээгдэхүүнүүд гаргах (ашигтай загвар, мэдээллийн бааз, селекцийн ололтууд, интеграль бичил схемүүдийн тодологиуд, үйлдвэрлэлийн нууц (ноу хау)),
- Ашиг орлого бүхий үйл ажиллагаанаас олсон хөрөнгөөр үйлдвэрлэсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд, тэдгээрийг боловсруулж гаргасан бүтээгдэхүүнүүдийг борлуулах,
- Газар зохион байгуулалт, хөрсний, агрохимийн болон эколог-токсикологийн судалгаа хийж гүйцэтгэх,
- Үл хөдлөх хөрөнгийн объектуудын улсын кадастрын бүртгэл, газрын үнэлгээ, байгаль орчны судалгаа, техникийн, мал эмнэлгийн дүгнэлт хийхтэй холбогдуулан шаардлагатай баримт бичгүүдийг бэлтгэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлэх,
- Хөдөө аж ахуйн техникийн туршилтын загварууд, түүнчлэн цахилгаанжуулалтын болон автоматжуулалтын хэрэгслүүдийн зураг төсөл гаргах, үйлдвэрлэх болон турших, тэдгээрийн засвар үйлчилгээ болон ашиглалтыг хэрэгжүүлэх,
- Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу сайн дурын гэрчилгээжүүлэлтийн зорилгоор бүтээгдэхүүний туршилт явуулах,
- Хэвлэн нийтлэх болон хэвлэлийн үйл ажиллагаа явуулах (сургалт аргазүйн материалууд, шинжлэх ухааны бүтээлүүдийн эмхэтгэлүүд, эрдэм шинжилгээний хурлуудын материалууд, сонин, бланк хэвлэн гаргах, хувилан олшруулах үйлчилгээ, сургалтын, сургалт аргазүйн, мэдээлэл-судалгааны болон бусад материалуудыг олшруулах),
- Ашиг орлого бүхий үйл ажиллагаанаас олсон хөрөнгөөр хэвлэн гаргасан буюу бүтээгдсэн дуу болон дүрстэй материал, сургалтын програм, цахим сурах бичиг, мэдээллийн болон бусад материал бэлтгэж борлуулах,
- Лавлагаа номзүйн болон номын сангийн үйлчилгээ, архив ашиглахтай холбогдсон үйлчилгээнүүд үзүүлэх,
- Мэдээлэл харилцаа холбооны систем, телематикийн салбарт үйлчилгээ явуулах, өгөгдөл дамжуулах үйлчилгээ үзүүлэх,
- Хуулийн этгээдүүд болон (буюу) хувь хүмүүст мэдээллийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх,
- Хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн цогцолбор дахь байгууллагын хөгжлийн бизнес төлөвлөгөө боловсруулах,
- Хөдөлмөр хамгааллын салбарт үйлчилгээ үзүүлэх, үүний дотор хөдөлмөрийн нөхцөлийн тусгай үнэлгээ хийх, ажил олгогч нар болон мэргэжилтнүүдийг хөдөлмөр хамгааллын асуудлуудад сургах,
- Төсөл, шинэ бүтээл, програм, шинжлэх ухааны болон сургалт-аргазүйн ном товхимлын экспертизын үйлчилгээ үзүүлэх,
- Үзэсгэлэн, яармаг, семинар, эрдэм шинжилгээний хурал, зөвлөлгөөн, чуулган, соёл олон түмний болон спортын арга хэмжээнүүд зохион байгуулж явуулах,



Unenbat
UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Их сургуулийн үйл ажиллагаанд тохирсон чиглэлүүдээр олон улсын хамтын ажиллагаа хэрэгжүүлэх,
- Тусгай зөвшөөрлийн дагуу улсын нууцад хамаарах мэдээлэл ашигласан ажил гүйцэтгэх,
- Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу иргэдэд түр оршин суух өрөө тасалгаануудыг дотуур байрандаа гаргаж өгөх,
- Тээврийн хэрэгсэл болон хөдөө аж ахуйн техникийн засвар болон техникийн үйлчилгээ явуулах,
- Агуулахын үйлчилгээ үзүүлэх,
- Тогтоосон журмын дагуу эд хөрөнгө зарлагадах үед гарах хар, өнгөт төмөрлөгийн хог хаягдал болон бусад төрлийн хоёрдогч түүхий эдийг тушаах,
- Их сургуулийн ажилтнууд, их сургуульд суралцагчид болон бусад хүмүүст биеийн тамир-эрүүл мэндийн болон морин спортын үйлчилгээ үзүүлэх; гипрометеорологийн салбарт үйл ажиллагаа явуулах; авто зогсоол, автомашины үйлчилгээний газар, түрээсийн цэгүүд, үүний дотор спортын хэрэгслийн түрээсийн үйл ажиллагаа зохион байгуулах болон ашиглах,
- Тээврийн үйлчилгээ болон ачаа өргөх машин механизмын ашиглалтын үйлчилгээ, өөрийн тээврийн хэрэгслээр хүн ам болон ачаа тээвэрлэх, автомашины түрээс,
- Өөрийн болон түрээсийн тайз, дэлгэц дээр жүжгийн болон дуурийн тоглолт, концерт болон бусад тайзны тоглолтуудыг зохион байгуулах ба найруулан тавих, кино үзүүлэх,
- Оросын Холбооны Улсад болон гадаадад мэргэжил дээшлүүлэх, дадлага хийх, Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэрээс гадуур суралцах ажлыг зохион байгуулж явуулах; орос хэлнээс гадаад хэл рүү, гадаад хэлнээс орос руу гадаадын хэвлэлд гарсан нийтлэлүүд, шинжлэх ухааны бүтээлүүдийн эмхэтгэлүүд, олон улсын арга хэмжээнүүдийн материалуудыг орчуулах хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх,
- Орчуулгын үйлчилгээ, үүний дотор олон улсын бага хурал, чуулган, зөвлөлгөөн, семинар, үзэсгэлэн болон бусад арга хэмжээнүүд зохион байгуулж явуулах үеэр синхрон (зэрэгцсэн) орчуулгын үйлчилгээ үзүүлэх,
- Концертын болон театрын танхимын үйл ажиллагаа, бусад үзвэр цэнгээний үйлчилгээ, мөн түүнчлэн амралт, зугаа цэнгэл, арга хэмжээнүүд зохион байгуулах үйл ажиллагаа,
- Их сургуулийн сургалт-эрдэм шинжилгээний болон спорт-эрүүл мэндийн цогцолборуудыг түшиглэн аялал, жуулчлалын үйл ажиллагаа явуулах, үүний дотор тухайн чиглэлээр сургууль, залуучуудын зуслан, хүүхдийн зуслан, хөдөлмөр амралтын газар, хязгаар нутгийн зуны сургууль, амралт сувиллын газрууд байгуулах,
- Хөдөө аж ахуйн өсгөвөр үйлдвэрлэн гаргахтай холбоотой үйл ажиллагаа,
- Тусгай зөвшөөрлийн дагуу холимог хөдөө аж ахуй эрхлэх (ургамал зүй болон мал аж ахуй)



UNENBAT
UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Тусгай зөвшөөрлийн дагуу цэцэрлэгт хүрээлэн, парк болон бусад ногоон байгууламжууд байгуулах, арчлах үйлчилгээ үзүүлэх, мал аж ахуйн чиглэлээр үйлчилгээ үзүүлэх,
- Зэрлэг ан амьтны агнуур, үржүүлэг, үүний дотор дээрх чиглэлээр үйлчилгээ үзүүлэх,
- Тэжээвэр болон зэрлэг шувуу үржүүлэх, борлуулах, загас агнуур, загас үржүүлэг болон эдгээр салбарт үйлчилгээ үзүүлэх, усжуулалт, хөрс сийрүүлэлт, хөрсний үржил шимийг хадгалах ба сэргээх үйлчилгээ үзүүлэх,
- Мод боловсруулалт, инженер-техникийн тоног төхөөрөмж, тавилга, эд зүйлс үйлдвэрлэх, борлуулах,
- Хөдөө аж ахуйн бараа үйлдвэрлэгчдэд (өмчийн бүх хэлбэрийн) зах зээлийн судалгаа хийх болон үр тариа борлуулах, үүний дотор үр тарианы интервенцийн замаар борлуулах үйлчилгээ үзүүлэх,
- Зурагзүйн болон геодезийн үйл ажиллагаа явуулах, ойн аж ахуй ба энэ салбарын үйлчилгээ үзүүлэх, мод бэлтгэл, мод үржүүлгийн газрын үйл ажиллагаа, тарьц суулгац, мод, бут ургуулах,
- Хуульзүйн үйлчилгээ, үүний дотор экспертиз хийх болон зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх,
- Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх,
- Нийтийн хоолны бүтээгдэхүүн худалдан авах, үйлдвэрлэх болон нийлүүлэх,
- Үйлдвэр аж ахуйн газруудын дэргэд цайны газар ажиллуулах,
- Сургалтын хөтөлбөрийн хүрээнд болон курс дугуйлангаар А, В, С, D болон E ангиллын автомашины жолооч, А, В, С, D, E, F ангиллын өөрөө явагч машины жолооч бэлтгэн гаргах,
- Гэрчилгээний дагуу барилгын ажлын захиалагч-гүйцэтгэчийн үүрэг гүйцэтгэх,
- Гэрчилгээний дагуу барилгын болон барилга засварын ажлууд гүйцэтгэх,
- Эрчим хүч хэмнэх болон эрчим хүчний хэмнэлттэй технологийн чиглэлээр төсөл боловсруулж хэрэгжүүлэх,
- Патент-мэдээллийн судалгаа хийх, патент авах захиалгын материал бүрдүүлэхтэй холбогдсон бичиг баримт хөтлөлт,
- Их сургуульд хадгалагдаж буй албан ёсны нэр, барааны тэмдэг, баримт бичгийн хуулбар болон соёлын үнэт зүйлсийг сурталчилгааны зорилгод ашиглах, мөн түүнчлэн уг эрхийг бусад хуулийн этгээдүүд болон хувь хүмүүст Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу олгох.

Тусгай зөвшөөрөл (лицензи), өөрөө удирдах байгууллагад гишүүнчлэлтэй юм уу өөрөө удирдах байгууллагаас олгодог тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх шаардлагатай үйл ажиллагаа эрхлэх Их сургуулийн эрх нь уг зөвшөөрлийг (лицензийг) хүлээн авсан өдрөөс буюу түүнд заасан өдрөөс, эсвэл хуулийн этгээд өөрөө удирдах байгууллагад элсэн орсон өдөр буюу өөрөө удирдах байгууллагаас тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон өдрөөс эхлэн үүсэх бөгөөд зөвшөөрлийн (лицензийн) хугацаа дуусгавар



Unenbat
UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

болох, өөрөө удирдах байгууллагын гишүүнчлэлээс гарах буюу өөрөө удирдах байгууллагаас олгосон тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болох үед мөн адил үгүй болно.

Их сургууль нь өөрийн үүсгэн байгуулагдсан зорилго хийгээд түүнд нийцсэн ашиг орлого бүхий үйл ажиллагаануудыг өөрийн зорилгыг биелүүлэх үүднээс гагцхүү тухайн үйл ажиллагаанууд нь үүсгэн байгуулах тухай баримт бичгүүдэд заасан байх нөхцөлд л хэрэгжүүлэх эрхтэй байна. Дээрх үйл ажиллагаанаас олсон орлого, мөн уг орлогоор худалдан авсан эд хөрөнгийг Их сургууль бие даан захиран зарцуулна.

Их сургууль нь энэхүү Дүрэмд заагаагүй төрлийн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх эрхгүй байна.

- 1.9. Их сургууль нь түүний эд хөрөнгийг өмчлөгчийн саналыг авахгүйгээр шинжлэх ухааны болон шинжлэх ухаан-техникийн салбар дахь төрийн бодлого боловсруулж, хууль-эрхзүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагад мэдэгдсэнээр оюуны үйл ажиллагааны үр дүнг (онцгой эрхүүдийг нь Их сургууль дангаараа (мөн бусадтай хамтран) эзэмшиж буй цахим тооцоолон бодох машины програм, өгөгдлийн сан, нээлт, ашигтай загвар, аж үйлдвэрийн загвар, селекцийн ололтууд, интеграль бичил схемын топологиуд, үйлдвэрлэлийн нууц (ноу хау)) практикт хэрэглэх (нэвтрүүлэх) үйл ажиллагаа явуулах аж ахуйн нийгэмлэг болон аж ахуйн нөхөрлөлийн үүсгэн байгуулагч (үүний дотор мөн бусад этгээдүүдтэй хамтран) байх эрхтэй. Ингэхдээ Их сургууль нь, аж ахуйн нийгэмлэг болон аж ахуйн нөхөрлөлийг үүсгэн байгуулж буй тухай мэдэгдлийг тухайн аж ахуйн нийгэмлэг буюу аж ахуйн нөхөрлөлийг хуулийн этгээдийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэснээс хойш 7 хоногийн дотор хүргүүлсэн байх ёстой.
- 1.10. Боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажилдаа (үүний дотор иргэдийг элсүүлэхэд тавигдах шаардлага, боловсролын агуулга болон боловсролын үйл ажиллагааны зохион байгуулалт, боловсролын гэрчилгээ олгох, суралцагчид болон ажилтнуудад эрх, нийгмийн баталгаа болон хөнгөлөлт олгох) Их сургууль нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомж, хууль-эрхзүйн бусад актууд болон энэхүү Дүрмийг удирдлага болгоно.
- 1.11. Их сургууль нь боловсролын зохих хөтөлбөрүүдээр зохих журмын дагуу улсын магадлан итгэмжлэлийн гэрчилгээ авсны дараагаар өөрийн төгсөгчдөд боловсролын зохих түвшний боловсролын болон мэргэшлийн улсын загвар бүхий гэрчилгээ олгох эрхтэй.
- 1.12. Их сургууль нь хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлж, ном, сурах бичиг, сургалтын болон сургалт-аргазүйн гарын авлага, шинжлэх ухааны, лавлах ном, тогтмол хэвлэл, мөн түүнчлэн сургалтын үйл явцтай холбоотой дуу-дүрсний бүтээгдэхүүн, сургалтын програм болон мэдээллийн материалууд гаргаж түгээн, шинжлэх ухааны болон бусад төрлийн үйл ажиллагаануудыг Оросын Холбооны Улсын хууль тогтоомж болон энэхүү Дүрмийн дагуу эрхэлнэ.
- 1.13. Их сургууль нь баригдаж буй Их сургуулийн объектуудын захиалагч-гүйцэтгэчийн үүргийг гүйцэтгэж, Их сургуульд хариуцуулсан үйлдвэрлэл-техникийн, сургалтын, эрдэм шинжилгээний зориулалттай болон дэд бүтцийн объектуудын ашиглалтыг хэрэгжүүлэн, Их сургуулийн хэрэгцээнд зориулж инженер-техникийн тоног төхөөрөмж, тавилга болон эд зүйлсийг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу үйлдвэрлэнэ.



UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- 1.14. Их сургууль нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу улсын нууц болон хязгаартай хүрээнд тараах мэдээллийг хамгаалах, техникийн ба бусад сувгуудаар алдагдахаас сэргийлэх арга хэмжээнүүдийг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.
- 1.15. Их сургууль нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу баримт бичгийн (удирдлагын, санхүү-аж ахуйн, боловсон хүчний болон бусад) бүрэн бүтэн байдлыг хариуцаж, тэдгээрийг баримт бичгийн тогтсон жагсаалтын дагуу улсын хадгаламжид шилжүүлэх явдлыг хангана.
- 1.16. Их сургууль нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу өөрийн эрх мэдлийн хүрээнд дайчилгааны бэлтгэл, иргэний хамгаалалт, онцгой байдлаас урьдчилан сэргийлэх болон арилгахтай холбогдсон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.
- 1.17. Их сургууль нь салбарууд үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, нэрийг нь өөрчлөх болон татан буулгахаас бусад тохиолдолд өөрийн бүтцийг бие даан тодорхойлно.
- 1.18. Их сургуулийн бүрэлдэхүүнд салбарууд, төлөөлөгчийн газрууд, хүрээлэнгүүд, үүний дотор эрдэм шинжилгээний, факультетууд (факультетын эрхтэй дээд сургуулиуд), тэнхимүүд, аспирантур ба докторантурууд, сургалтын, эрдэм шинжилгээний, мэдээлэл-судалгааны салбарууд, нууц мэдээллийн хэлтэс, мэргэжлийн нэмэлт боловсролын, хичээлээс гадуур ба хүмүүжлийн ажлын, их дээд сургуульд элсэлтийн өмнөх бэлтгэлийн салбарууд, дадлагын сургалтын (салбарын бизнес инкубатор, сургалт-туршилтын талбай, ногооны, селекцийн болон мал аж ахуйн станцууд, сургалт-туршилтын зөгийн аж ахуй, агнуурын аж ахуйн) болон туршилтын ажлын баазууд, номын сан, хэвлэлийн газар, сонин сэтгүүлийн редакци, боловсрол, эрдэм шинжилгээ, судлагаа шинжилгээний, аргазүйн, хэвлэл нийтлэлийн, санхүү-эдийн засгийн, мэдээлэл-судалгааны, үйлдвэрлэлийн болон Оросын Холбооны Улсын хууль тогтоомж болон энэхүү Дүрэмд заасан бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэгч удирдлагын болон бүтцийн бусад салбар нэгжүүд багтана.

Түүнчлэн, Их сургуулийн бүрэлдэхүүнд үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтцийн объектууд, үүний дотор дотуур байрнууд, цайны газрууд, морин спортын ба спорт-эрүүл мэндийн цогцолборууд, биеийн тамир-эрүүл мэндийн клубууд, сувиллын газрууд болон бүтцийн бусад салбар нэгжүүд мөн багтана.

- 1.19. Их сургуулийн салбарууд нь Их сургуулийн байгаа газраас өөр газарт байрласан түүний бүтцийн тусдаа салбарууд байх бөгөөд түүний үүргүүдийг, үүний дотор төлөөлөгчийн газрын үүргийг бүхэлд нь буюу хэсэгчлэн бие даан хэрэгжүүлнэ.

Их сургуулийн салбарууд нь хуулийн этгээд биш байх бөгөөд энэхүү Дүрэм болон тухайн салбартай холбогдуулж Их сургуулийн захирлын баталсан журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

Их сургуулийн салбаруудыг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулж, нэрийг нь өөрчлөх ба татан буулгана. Их сургуулийн салбарууд нь хуулийн этгээдийн улсын нэгдсэн бүртгэлийн жагсаалтад орсон байна.

Их сургууль нь салбаруудын ажлын цагийн хуваарь, салбаруудын санхүү-аж ахуйн үйл ажиллагааны төлөвлөгөөг бие даан баталж, улсын даалгавар биелүүлэхтэй холбогдсон нормативын зардлуудыг нөхөх тэтгэмж, бусад зориулалттай тэтгэмж, хувь хүмүүсийн өмнө хүлээсэн олон нийтийн үүргийн



Unenbat
UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

биелэлтэд зориулагдсан төсвийн хөрөнгө, санхүүгийн бусад тусламжийг салбаруудад хуваарилан хүргэнэ.

Их сургууль нь дараах салбаруудтай байна:

- Холбооны дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага “Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль”-ийн Ачинскийн салбар (ХДБУТББ Красноярскийн ХААУИС-ийн Ачинскийн салбар), байршил: 662150, Красноярскийн хязгаар, Ачинск хот, Коммунистическая гудамж 49. Оросын Холбооны Улсын Хүнс, хөдөө аж ахуйн яамны 1998 оны 2-р сарын 24-ний өдрийн “Улсын боловсролын байгууллага Красноярскийн хязгаар дахь Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургуулийн Ачинскийн салбар байгуулах тухай” №101 тоот тушаалыг үндэслэн Улсын боловсролын байгууллага Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургуулийн Ачинскийн салбар нэртэй байгуулагдсан; Оросын Холбооны Улсын Хөдөө аж ахуйн яамны 2007 оны 11-р сарын 13-ны өдрийн “Красноярскийн хязгаар болон Бүгд Найрамдах Хакасси улс дахь ХДБУТББ Красноярскийн ХААУИС-ийн салбаруудын нэрийг өөрчлөх тухай” №567 тоот тушаалаар Холбооны мэргэжлийн дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага “Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль”-ийн Ачинскийн салбар болгож өөрчилсөн; Оросын Холбооны Улсын Хөдөө аж ахуйн яамны 2011 оны 5-р сарын 23-ны өдрийн “ХДБУТББ-ууд болон тэдгээрийн салбаруудын нэрийг өөрчлөх тухай” №132 тоот тушаалаар Холбооны мэргэжлийн дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага “Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль”-ийн Ачинскийн салбар болсон; Оросын Холбооны Улсын Хөдөө аж ахуйн яамны 2014 оны 9-р сарын 15-ны өдрийн “ХДБУТББ-ууд болон тэдгээрийн салбаруудын нэрийг өөрчлөх тухай” №357 тоот тушаалаар Холбооны мэргэжлийн дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага “Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль”-ийн Ачинскийн салбар болж өөрчлөгдсөн.
- Холбооны мэргэжлийн дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага “Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль”-ийн Хакассийн салбар (ХДБУТББ Красноярскийн ХААУИС-ийн Хакассийн салбар), байршил: 662600, Бүгд Найрамдах Хакасси улс, Абакан хот, Советская гудамж 32. Оросын Холбооны Улсын Хүнс, Хөдөө аж ахуйн яамны 1998 оны 2-р сарын 24-ний өдрийн “Улсын боловсролын байгууллага Красноярскийн хязгаар дахь Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургуулийн Хакассийн салбар байгуулах тухай” №102 тоот тушаалыг үндэслэн Улсын боловсролын байгууллага Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургуулийн Хакассийн салбар нэртэй байгуулагдсан; Оросын Холбооны Улсын Хөдөө аж ахуйн яамны 2007 оны 11-р сарын 13-ны өдрийн “Красноярскийн хязгаар болон Бүгд Найрамдах Хакасси улс дахь ХДБУТББ Красноярскийн ХААУИС-ийн салбаруудын нэрийг өөрчлөх тухай” №567 тоот тушаалаар Холбооны мэргэжлийн дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага “Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль”-ийн Хакассийн салбар болгож өөрчилсөн; Оросын Холбооны Улсын Хөдөө аж ахуйн яамны 2011 оны 5-р сарын 23-ны өдрийн “ХДБУТББ-ууд болон тэдгээрийн салбаруудын нэрийг өөрчлөх тухай” №132 тоот тушаалаар Холбооны мэргэжлийн дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага “Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль”-ийн Хакассийн салбар болсон; Оросын Холбооны Улсын Хөдөө аж ахуйн яамны 2014 оны 9-р сарын 15-ны өдрийн “ХДБУТББ-ууд болон тэдгээрийн салбаруудын нэрийг өөрчлөх тухай” №357 тоот тушаалаар Холбооны мэргэжлийн дээд боловсролын улсын төсвийн



UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

боловсролын байгууллага "Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль"-ийн Хакасскийн салбар болж өөрчлөгдсөн.

1.20. Их сургуулийн төлөөлөгчийн газрууд нь түүний бүтцийн бие даасан тусдаа салбар нэгжүүд байх бөгөөд Их сургуулиас өөр газарт байрласан байна.

Их сургуулийн салбаруудыг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулж, нэрийг нь өөрчлөх ба татан буулгана.

Төлөөлөгчийн газрын эрхзүйн байдал болон үүргүүд нь Их сургуулийн эрдмийн зөвлөлөөс баталсан журмын дагуу тодорхойлогдоно.

Их сургууль нь дараах төлөөлөгчийн газруудтай байна:

- 1) Холбооны дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага "Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль"-ийн Минусинскийн төлөөлөгчийн газар, шуудангийн хаяг: Февральская гудамж 9, Минусинск хот, Красноярскийн хязгаар, 662600.
- 2) Холбооны дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага "Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль"-ийн Канскийн төлөөлөгчийн газар, шуудангийн хаяг: Земледелия гудамж 39, байр 1, Канск хот, Красноярскийн хязгаар, 663600
- 3) Холбооны дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага "Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль"-ийн Шушенскийн төлөөлөгчийн газар, шуудангийн хаяг: Вокзальная гудамж 2, Шушенское суурин, Красноярскийн хязгаар, 662710
- 4) Холбооны дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага "Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль"-ийн Эвенкийн төлөөлөгчийн газар, шуудангийн хаяг: Школьная гудамж 24 А, Тура суурин, Эвенкийн өөртөө засах тойрог, Красноярскийн хязгаар, 648000
- 5) Холбооны дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага "Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль"-ийн Красноярскийн хязгаарын Рыбинскийн районы Заозерный хот дахь төлөөлөгчийн газар, шуудангийн хаяг: Гагарины гудамж, 23А байр, Заозерный хот, Красноярскийн хязгаар, 663961
- 6) Холбооны дээд боловсролын улсын төсвийн боловсролын байгууллага "Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль"-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар, шуудангийн хаяг: Жалханз Хутагт Дамдинбазарын гудамж – 7, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс, 16066.

Их сургууль нь төлөөлөгчийн газрын ажлын цагийн хуваарийг бие даан батална. Төлөөлөгчийн газрууд нь боловсролын, эрдэм шинжилгээний, аж ахуйн, нийгмийн болон бусад үйл ажиллагаа бие даан эрхлэхгүй.

1.21. Их сургуулийн дэргэд үйлдвэрчний эвлэлийн ба олон нийтийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж болох бөгөөд үйл ажиллагааг нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор зохицуулна.

Их сургуулийн дэргэд улс төрийн нам, улс төр-олон нийтийн байгууллага, шашны хөдөлгөөн болон бүлэглэл байгуулах, үйл ажиллагаа явуулахыг хориглоно.




UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- 1.22. Их сургууль нь тэтгэлгийн зөвлөлүүд байгуулах, ашгийн бус байгууллагуудын тухай Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй холбоонд сайн дураар элсэн орох ба нэгдэх эрхтэй.
- 1.23. Их сургуулийн дэргэдэх олон нийтийн байгууллагууд болон төр-олон нийтийн нэгдлүүд нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулна.
- 1.24. Их сургуульд суралцагчдын ашиг сонирхлыг суралцагчдын олон нийтийн байгууллага төлөөлнө. Их сургууль болон суралцагчдын олон нийтийн байгууллагын харилцааг Их сургуулийн дүрэм ба Их сургууль, суралцагчдын олон нийтийн байгууллагын хооронд байгуулсан гэрээгээр тодорхойлно.
- 1.25. Их сургуулийн дүрэм, түүнд оруулах нэмэлт болон (буюу) өөрчлөлтүүд нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан журмаар батлагдана. Дүрэм ба түүнд оруулах нэмэлт болон (буюу) өөрчлөлтүүд нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу бүртгүүлсэн байвал зохино.

Мөрдөгдөж буй Дүрэм, түүнд нэмэлт болон (буюу) өөрчлөлт оруулах тухай саналуудтай танилцах боломжийг нийт ажилтнууд болон суралцагчдад олгож, мөн Их сургууль дээр эдгээр саналуудыг чөлөөтэй авч хэлэлцэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2. ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ

- 2.1. Боловсролын харилцаа үүсэх үндэслэл нь тухайн этгээдийг суралцуулахаар юм уу завсрын аттестатчилал авахаар, эсхүл улсын эцсийн аттестатчилал авахаар элсүүлэн авсан тухай Их сургуулиас гаргасан захирамж бичиг байна.

Их сургууль нь ерөнхий боловсролын сургалтын үндсэн хөтөлбөрүүд, мэргэжлийн дунд боловсролын сургалтын хөтөлбөрүүдээр, мөн дээд боловсролын сургалтын хөтөлбөрүүдээр бакалаврын хөтөлбөрөөр, мэргэшүүлэх хөтөлбөрөөр, магистрын хөтөлбөр болон аспирантураар эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх боловсон хүчин бэлтгэх хөтөлбөр, ерөнхий боловсролын нэмэлт хөтөлбөрүүд, мэргэжлийн боловсролын нэмэлт хөтөлбөрүүдээр тус тусад нь суралцуулахаар элсэлт зохион байгуулж явуулна.

- 2.2. Их сургуулийн элсэлтийг Оросын Холбооны Улсын хууль тогтоомж болон энэхүү Дүрмийн дагуу хэрэгжүүлнэ. Их сургууль нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомж болон боловсролын салбар дахь төрийн бодлого боловсруулах, хууль-эрхзүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтоосон элсэлтийн журмыг зөрчихгүйгээр жил бүрийн элсэлтийн дүрмийг бие даан боловсруулж батална.

- 2.3. Мэргэжлийн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт элсэхийг, хэрэв хуулинд өөрөөр заагаагүй, бол бүрэн дунд буюу бүрэн дундаас доошгүй боловсрол бүхий этгээдүүдэд зөвшөөрдөг болно.

Үндсэн ерөнхий боловсролын суурин дээр мэргэжлийн дунд боловсрол олгох үйл ажиллагаа нь мэргэжлийн дунд боловсролын зохих сургалтын хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсрол нэг зэрэг эзэмшүүлэхтэй хамт хэрэгжинэ.

- 2.4. Бакалаврын юм уу мэргэшүүлэх хөтөлбөрүүдэд үндсэн ерөнхий (бүрэн дунд) боловсрол бүхий этгээдүүд хамрагдахыг зөвшөөрнө.




UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- 2.5. Магистрын хөтөлбөрүүдэд аль ч түвшний дээд боловсрол бүхий этгээдүүд хамрагдаж болно.
- 2.6. Аспирантурт эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх боловсон хүчин бэлтгэх хөтөлбөрт дээдээс доошгүй (мэргэшүүлэх болон магистрын) боловсрол бүхий этгээдүүдийг элсүүлнэ.
- 2.7. Мэргэжлийн боловсролын нэмэлт хөтөлбөрүүдийг эзэмшихэд мэргэжлийн дунд болон (буюу) дээд боловсролтой, эсхүл болох гэж байгаа этгээдүүдийг элсүүлнэ.

Ерөнхий боловсролын нэмэлт хөтөлбөрүүдийг эзэмшихэд, хэрэв хэрэгжүүлж буй тухайн хөтөлбөрийн онцлогоос шалтгаалсан өөр зүйл үгүй бол, ямар ч этгээдийг боловсролын түвшин харгалзахгүйгээр элсүүлнэ.

- 2.8. Мэргэжлийн дунд боловсролын сургалтын хөтөлбөрүүдэд, хэрэв Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол, холбооны төсвийн хөрөнгийн тусламжтайгаар, Оросын Холбооны Улсын субъектуудын төсвийн хөрөнгө ба орон нутгийн төсвийн хөрөнгөөр суралцагч элсүүлэх нь бүх нийтэд нээлттэй байна. Элсэгчдээс тодорхой хэмжээгээр уран бүтээлийн авьяас чадвар, бие бялдрын болон (буюу) сэтгэл санааны чанартай байхыг шаардсан мэргэжил, мэргэшлээр суралцагч элсүүлэхдээ Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу тогтоосон журмаар элсэлтийн сорил авна. Элсэгчдийн тоо хэмжээ холбооны төсвийн хөрөнгийн тусламжтайгаар, Оросын Холбооны Улсын субъектуудын төсвийн хөрөнгө ба орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүждэг орон тооноос давсан тохиолдолд мэргэжлийн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт суралцагчдыг элсүүлэхдээ Их сургууль нь элсэгчдийн авч ирсэн боловсролын гэрчилгээнд заасан ерөнхий боловсролын болон дунд боловсролын дүнгийн үзүүлэлтүүдийг харгалзана.
- 2.9. Магистрын хөтөлбөр, аспирантурт эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх боловсон хүчин бэлтгэх хөтөлбөрт суралцагчдын элсэлтийг, хэрэв Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол, Их сургуулиас бие даан явуулдаг элсэлтийн сорилын үр дүнгээр зохион байгуулж явуулна.
- 2.10. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрүүдэд суралцахаар элсэгчид нь элсэлтийн дүрэмд заасны дагуу Их сургууль үр дүнг нь харгалзан үзэх өөрсдийн хувийн амжилтын талаарх мэдээллийг гаргаж өгөх эрхтэй байна.
- 2.11. Холбооны боловсролын улсын стандартуудын дагуу, хэрэв уг иргэн тухайн түвшний боловсролыг анх удаагаа олж авч байгаа бол, Их сургууль нь Оросын Холбооны Улсын иргэдийн мэргэжлийн үнэгүй дунд боловсролтой болох, мөн түүнчлэн сонгон шалгаруулалтын үндсэн дээр дээд боловсрол олж авах (бакалавр, мэргэшил, магистр, дээд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх) эрхийг хэрэгжүүлнэ.
- 2.12. Дээд боловсролын дараах хөтөлбөрүүдээр суралцах нь хоёр дахь буюу дараачийн дээд боловсрол олж авах явдал болно:
- Бакалаврын буюу мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдээр - бакалаврын диплом, мэргэшлийн диплом буюу магистрын диплом бүхий этгээдүүд,
 - Магистрын хөтөлбөрүүдээр - мэргэшлийн диплом буюу магистрын диплом бүхий этгээдүүд,



UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх боловсон хүчин бэлтгэх хөтөлбөрүүдээр – аспирантур төгссөн диплом буюу дэд эрдэмтний диплом бүхий этгээдүүд.
- 2.13. Их сургуулийн элсэлт нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасны дагуу элсэлтийн үед онцгой (давуу) эрх олгогдсон этгээдүүдээс бусад нийт элсэгчдийн хувьд элсэлтийн адил тэгш нөхцөлөөр хангах зарчмаар явагдана.
- 2.14. Бакалаврын хөтөлбөр болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдээр суралцагчид элсүүлэхдээ, хэрэв Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол, улсын элсэлтийн ерөнхий шалгалтын (цаашид ЭЕШ гэх) үр дүнг үндэслэнэ.
- 2.15. Бакалаврын хөтөлбөр болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдээр суралцагчид элсүүлэх үед ЭЕШ-ын дүнгийн хүчинтэй хугацааг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу тогтооно.
- 2.16. Их сургуульд элсэлт авч буй мэргэшил буюу бэлтгэх чиглэлтэй тохирох ерөнхий боловсролын эрдмийн ЭЕШ-ын онооны хамгийн доод хэмжээ, мөн түүнчлэн зорилтот элсэлтийг Их сургуулиас тогтоож өгнө. Ингэхдээ тохиолдолд ЭЕШ-ын онооны хамгийн доод хэмжээ нь Бакалаврын хөтөлбөр болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдээр элсэн суралцахад шаардагдах ЭЕШ-ын онооны хэмжээ болон боловсролын салбарт хяналт шалгалт хэрэгжүүлэгч холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтоосон хэмжээнээс доогуур байж болохгүй.
- 2.17. Гадаадын иргэдэд, хэрэв Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол, Бакалаврын хөтөлбөр болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдэд Их сургуулиас бие даан явуулдаг элсэлтийн сорилын үр дүнгээр элсэн суралцах эрхийг олгоно.
- 2.18. Бакалаврын хөтөлбөр болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдэд мэргэжлийн дунд буюу дээд боловсролтой хүмүүсийг арга хэлбэр, тоо жагсаалтыг нь Их сургуулиас тогтоосон элсэлтийн сорилын үр дүнгээр элсүүлэн суралцуулна.
- 2.19. Их сургууль нь боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах болон хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар, үүний дотор суралцагч элсүүлэх дүрэм, суралцагчдын суралцах горим, суралцагчдын сурлагын амжилтын урсгал шалгалт болон завсрын аттестатчилал явуулах хугацаа ба журам, суралцагчдыг шилжүүлэх, хасах ба сэргээх үндэслэл болон журам, боловсролын байгууллага ба суралцагчид болон (буюу) насанд хүрээгүй суралцагчдын эцэг эхийн (хууль ёсны төлөөлөгчид) хоорондын харилцаа үүсэх, түр зогсох буюу дуусгавар болох зэргийг зохицуулах журмын талаар дотоод нормативын актуудыг баталж гаргана.
- 2.20. Их сургууль нь элсэгчдийг болон (буюу) тэдгээрийн эцэг эхийг (хууль ёсны төлөөлөгчид) Дүрэм, боловсролын үйл ажиллагаа явуулах эрхийн тусгай зөвшөөрөл, улсын магадлан итгэмжлэлийн гэрчилгээ, боловсролын хөтөлбөрүүд болон боловсролын үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх ажил, суралцагчдын эрх, үүргүүдийг зохицуулагч бусад баримт бичгүүдтэй танилцуулна. Сонгон шалгаруулалтын үндсэн дээр элсүүлэх үед элсэгчид явуулж буй сонгон шалгаруулалт болон түүний үр дүнгийн талаарх мэдээллийг мөн өгнө.
- 2.21. Мэргэжлийн боловсролын нэмэлт хөтөлбөрүүдээр, мөн түүнчлэн төлбөрийг нь хувь хүн болон (буюу) хуулийн этгээд төлж буй орон тоон дээр суралцагч элсүүлэхдээ Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу Их сургуулийн дотоод нормативын актуудаар тогтоосон нөхцөл болзлуудын дагуу элсүүлнэ.



Unenbat
UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- 2.22. Их сургууль нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасны дагуу элсэлтийн хяналтын тооны хүрээд зорилтот элсэлт болон зорилтот сургалтыг явуулах эрхтэй байна.
- 2.23. Их сургууль нь боловсролын тухай Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасны дагуу хувь хүн болон (буюу) хуулийн этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр сургалтын төлбөрийг тэдгээрээр гүйцэтгүүлэн тогтоосон элсэлтийн хяналтын тооноос илүү тоогоор элсэлт авах эрхтэй байна.
- 2.24. Улсаас магадлан итгэмжлэл авсан бакалаврын хөтөлбөр болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдээр элсүүлэхдээ Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасны дагуу иргэдэд тусгай эрх олгож байж болно.
- 2.25. Элсэгчид нь орос хэлээр элсэлтийн сорил өгнө.
- 2.26. Элсэлтийн сорил явуулах болон Их сургуульд элсүүлэх үед элсэлтийн, эрдмийн шалгалтын, аттестатчиллын болон давж заалдах комиссууд байгуулагдах бөгөөд тэдгээрийн бүрдүүлэх журам, бүрэлдэхүүн, бүрэн эрх ба үйл ажиллагааг Их сургуулийн эрдмийн зөвлөлөөс гаргаж улмаар Их сургуулийн захирлын баталсан зохих журмаар зохицуулна.
- 2.27. Их сургуулийн элсэлтийн комиссын дарга нь захирал байна.
- 2.28. Элсэлтийн комиссын үйл ажиллагаа, бичиг баримт хөтлөлт, мөн түүнчлэн элсэгчид болон тэдгээрийн эцэг эхтэй хийх улзалтуудыг хариуцлагатай нарийн бичгийн дарга зохион байгуулах бөгөөд түүнийг Их сургуулийн захирал томилно.
- 2.29. Их сургуульд суралцагч нэгбүр дээр тогтсон журмын дагуу хувийн хэрэг хөтлөнө.

3. ИХ СУРГУУЛИЙН БОЛОВСРОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1. Янз бүрийн түвшний боловсролын хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд тавих ерөнхий шаардлагуудыг боловсролын тухай Оросын Холбооны Улсын хууль тогтоомж, боловсролын салбар дахь төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас гаргасан нормативын актуудаар тогтоож өгнө.
- 3.2. Их сургууль дахь боловсролын үйл ажиллагаа орос хэл дээр явагдана. Боловсролын зарим нэг хөтөлбөрүүд нь эрдмийн зөвлөлийн шийдвэрээр бүхэлдээ буюу хэсэгчлэн гадаад хэлээр явагдаж байж болно.
- 3.3. Сургалтын хөтөлбөрүүдийг Их сургууль бие даан боловсруулж батална. Улсаас магадлан итгэмжлэл авсан байх шаардлагатай сургалтын хөтөлбөрүүд нь холбооны боловсролын улсын стандартуудын дагуу, үндсэн сургалтын зохих жишиг хөтөлбөрүүдийг харгалзан боловсруулагдана.
- 3.4. Сургалтын хөтөлбөр гэдэг нь Их сургуулийн шийдвэрээр сургалтын хөтөлбөрийн ерөнхий тодорхойлолт, сургалтын төлөвлөгөө, сургалтын календарчилсан график, хичээлийн ажлын хөтөлбөр (модуль), дадлагын хөтөлбөр, үнэлгээний хэрэгсэл, аргазүйн материалууд, бусад бүрдэл хэсгүүд маягаар боловсролын хөтөлбөрийн бүрэлдэхүүнд оруулсан боловсролын ерөнхий тодорхойлолтууд (хэмжээ, агуулга, төлөвлөж буй үр дүн), зохион байгуулалтын болон сурган хүмүүжүүлэх нөхцөлүүд, аттестатчиллын хэлбэрүүдийн цогц юм.



Unenbat
UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- 3.5. Их сургууль нь сургалтын хөтөлбөрийг баримт бичгийн багц хэлбэрээр боловсруулах бөгөөд шинжлэх ухаан, соёл, эдийн засаг, техник, технологи болон нийгмийн салбарын хөгжлийг харгалзан түүнийгээ шинэчилж байдаг болно.

Сургалтын хөтөлбөр боловсруулах, батлах журмыг Их сургууль тогтооно.

- 3.6. Боловсрол олж авах хэлбэр ба сургалтын арга хэлбэрүүдийг холбооны боловсролын улсын стандартуудаар тогтоож өгсөн байна. Боловсролын стандартаар тогтоогдсон сургалтын өөр өөр арга хэлбэрүүдийг хослуулахыг зөвшөөрнө.
- 3.7. Их сургууль нь сургалтын хөтөлбөрүүдээ Оросын Холбооны Улсын хуульзүйн актуудаар тавигддаг шаардлагуудад нийцүүлэн хэрэгжүүлнэ.
- 3.8. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд сургалтын арга ба хэрэгсэл, сургалтын технологи болон сургалт-аргазүйн хангамжийн сонголтыг хийдээ суралцагчдыг сургалтын хөтөлбөр эзэмшилтийн төлөвлөсөн хэмжээнд хүргэх шаардлагыг үндэслэн, мөн түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй болон эрүүл мэндийн хувьд хязгаарлагдмал чадвар бүхий суралцагчдын хувийн чадавх, боломж бололцоог харгалзан Их сургууль бие даан гүйцэтгэнэ.
- 3.9. Сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлыг мэдээлэл, мэдээллийн технологи болон мэдээллийг хамгаалах тухай Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан шаардлагуудыг харгалзан гүйцэтгэнэ.
- 3.10. Улсын нууцад хамаарах мэдээлэл агуулсан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлыг улсын нууцын тухай Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан шаардлагуудыг харгалзан гүйцэтгэнэ.
- 3.11. Их сургууль нь сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт явуулж эхлэхээс өмнө хичээлийн цагийн хуваарийг сургалтын төлөвлөгөө болон сургалтын календарчилсан графикайн дагуу гаргана.

Бүх төрлийн танхимын хичээлийн 1 цагийн үргэлжлэх хугацааг 45 минутаар тогтооно. Нэг хичээл нь ихэнхдээ 2 цаг байна. Хичээлүүдийн хооронд завсарлагаа нь 10-аас доошгүй минут байна.

Дээд боловсролын холбооны улсын стандартуудад заасан практикийг Их сургууль болон байгууллагуудын хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр тэдгээрийн өмчлөлийн зохион байгуулалт-эрхзүйн хэлбэрээс үл хамааран, мөн түүнчлэн Их сургуулийн сургалт-туршилтын салбар нэгжүүдэд авч хэрэгжүүлнэ.

- 3.12. Сургалтын хөтөлбөрийг сүлжээний хэлбэрээр хэрэгжүүлэх тохиолдолд Их сургууль нь өөрийн тогтоосон журмын дагуу сургалтын үр дүнг хичээлүүдийн (модулиуд) сургалт ба сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцож буй бусад байгууллагад хийсэн дадлагаар тооцно.
- 3.13. Сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн дунд буюу дээд боловсрол бүхий суралцагч эзэмшиж байгаа болон (буюу) мэргэжлийн дунд боловсролын сургалтын хөтөлбөрөөр юм уу дээд боловсролын өөр ямар нэг хөтөлбөрөөр суралцаж байгаа, эсвэл тухайн сургалтын хөтөлбөрийг уг хөтөлбөрийн дагуу Их сургуулиас боловсролын стандартад нийцүүлэн тогтоосон дээд боловсрол эзэмших хугацаатай харьцуулбал илүү богино хугацаанд сургалтын хөтөлбөрийг эзэмших боломж олгохуйц чадвар болон (буюу) түвшнийх байх бол Их сургуулийн шийдвэрээр Их сургуулийн дотоод хууль дүрэмд заасан журмын дагуу тухайн суралцагчийг ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний дагуу түргэвчлэн сургана.



Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn


UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

3.14. Түргэвчилсэн сургалтаар сургалтын хөтөлбөрийн дагуух дээд боловсрол олж авах хугацааг дараах аргуудын тусламжтайгаар богиносгоно:

- Суралцагчийн мэргэжлийн дунд боловсрол болон (буюу) дээд боловсрол (сургалтын өөр хөтөлбөрөөр), мөн түүнчлэн мэргэжлийн нэмэлт боловсрол олж авах үедээ (хэрэв байгаа бол) үзэж судалсан зарим нэг хичээлүүд (модулиуд) болон (буюу) зарим нэг дадлагын (хийж гүйцэтгэсэн) үр дүнг бүхэлд нь буюу хэсэгчлэн (дахин аттестатчилах юм уу дахин тооцох маягаар) тооцох (цаашид сурлагын үр дүнг тооцох гэх).

- Сургалтын хөтөлбөрийн эзэмшилтийг эрчимжүүлэх.

3.15. Түргэвчлэн сургах тухай шийдвэрийг Суралцагчийн гаргасан өргөдлийг үндэслэн Их сургууль гаргана.

3.16. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ сүлжээний хэлбэрийг ашиглах, суралцагчийг сургалтын янз бүрийн хэлбэрүүдийг хослуулсан сургалтад шилжүүлэхдээ түүний бичгээр гаргасан зөвшөөрлийн дагуу хэрэгжүүлнэ.

3.17. Сургалтын хөтөлбөрүүдийн дагуу сургалтын янз бүрийн хэлбэрүүдийг хослуулах, дээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ сүлжээний хэлбэрийг ашиглах, түргэвчилсэн сургалтын үед боловсролын үйл явцыг зохион байгуулах ажлыг Их сургуулийн дотоод хууль дүрмийг баримтлан хэрэгжүүлнэ.

3.18. Их сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй болон эрүүл мэндийн хувьд хязгаарлагдмал чадвар бүхий этгээдүүдийн сургалтын хөтөлбөрийн дагуу боловсрол эзэмших хугацааг тухайн сургалтын хөтөлбөрийн дагуу зохих хэлбэрээр боловсрол эзэмших хугацаатай харьцуулбал боловсролын стандартаар тогтоосон хэмжээнд уг суралцагчийн бичгээр гаргасан өргөдлийг үндэслэн нэмэгдүүлнэ.

3.19. Их сургууль нь суралцагчдын багаар ажиллах чадвар, хувь хүний харилцааны дадал төлөвшүүлж, шийдвэр гаргах чадвар, манлайлагчийн чанаруудыг хөгжүүлсэн хичээл сургуулийн шинэлэг хэлбэрүүдийг ашиглахыг заасан байдаг болно (үүнд, шаардлагатай бол интерактив лекц, бүлгийн маргаан, хэлэлцүүлэг, дүрийн тоглолтууд, сургалтууд явуулж, нөхцөл байдал болон дууриалгасан загварт дүн шинжилгээ хийх, Их сургуулиас явуулж буй шинжлэх ухаанч судалгаануудын үр дүнд суурилсан, мөн төгсөгчдийн мэргэжлийн үйл ажиллагааны онцлог болон ажил олгогчдын эрэлт хэрэгцээг харгалзан бий болгосон курсуудын хэлбэрээр хичээлүүдийг (модулиуд) заах).


Сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ суралцагчдын бие бялдрын болон сэтгэцийн эрүүл мэндэд хор хөнөөл учруулахуйц сургалт хүмүүжлийн арга хэрэгсэл, боловсролын технологиудыг ашиглахыг хориглоно.

3.20. Сургалтын хөтөлбөрийн дагуу боловсролын үйл явцыг зохион байгуулах явцад суралцагчдын багштай харьцаж ажиллах хугацааны доод хэмжээ, мөн түүнчлэн лекцийн болон семинарын хэлбэрээр явагдах хичээлийн дээд хэмжээг Их сургуулийн дотоод хууль дүрмээр тогтооно.

3.21. Үнэлгээний арга хэлбэр, систем, суралцагчдын завсрын аттестатчилал явуулах журам, үүний дотор хүндэтгэх шалтгаанаар юм уу өр төлбөртэйн улмаас завсрын аттестатчилалд орж чадаагүй суралцагчийн зохих сорилуудыг өгөх хугацааг тогтоох журам, мөн түүнчлэн суралцагчдын завсрын аттестатчилал явуулах хугацааг Их сургуулийн дотоод хууль дүрмээр тогтооно.



Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn


UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

- 3.22. Бие даан суралцах хэлбэрээр (хэрэв тухайн сургалтын хөтөлбөрөөр бие даан суралцах хэлбэрээр дээд боловсрол олж авахыг боловсролын стандартаар зөвшөөрсөн бол) сургалтын хөтөлбөр эзэмшиж буй этгээдүүд, мөн түүнчлэн улсаас магадлан итгэмжлэгдээгүй хөтөлбөрөөр суралцаж байсан хүмүүсийг завсрын аттестатчилал болон улсын шалгалтад оруулах зорилгоор Их сургуульд экстернатаар элсүүлж болно.

Их сургуулиас тогтоосон хугацаанд экстернатад бүртгэж авсны дараагаар, гэхдээ бүртгэсэн өдрөөс хойш 1 сарын дотор, завсрын аттестатчилал болон (буюу) улсын шалгалт өгөх хуваарийг тусгасан суралцагчийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг батална.

Экстернээр суралцагчдыг Их сургуульд элсүүлэх нөхцөл ба журмыг (үүний дотор суралцагчдын экстернатад суралцах хугацааг тогтоох, мөн тэдгээрийн завсрын аттестатчилал болон (буюу) улсын шалгалт өгөх хугацааг тогтоох журам) Их сургуулийн дотоод хууль дүрмээр тогтооно.

- 3.23. Их сургуульд суралцагч нь боловсролын салбарт төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хийх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтоосон журамд заасан тохиолдлуудад төлбөртэй сургалтаас төлбөргүй сургалтад шилжих эрхтэй байна.

- 3.24. Эмнэлгийн заалтаар болон бусад онцгой тохиолдлуудад боловсролын салбарт төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хийх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтоосон журмын дагуу Их сургуульд суралцагчдад жилийн чөлөө олгож болно. Мөн жирэмсний болон хүүхэд гаргасны амралт, хүүхдээ 3 нас хүртэл асрах амралтыг холбооны зохих хуулиудын дагуу олгоно.

- 3.25. Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан тохиолдлуудад Их сургуулийг төгсөгчийн хувьд улсын шалгалтыг заавал авах бөгөөд сургалтын хөтөлбөрийг бүрэн хэмжээгээр үзэж судалсны дараагаар шалгалтыг өгүүлнэ.

- 3.26. Сургалтын үндсэн хөтөлбөрүүдээр суралцагчдад улсын шалгалт өгсний дараагаар боловсрол эзэмшсэнтэй холбогдуулан суралцагчдыг сургуулиас хасах хүртэл зохих сургалтын үндсэн хөтөлбөрийг эзэмших хугацааны хүрээнд тэдний өргөдлийн дагуу амралт олгогдоно.


Их сургуулийн төгсөгч нь хасах тухай захирлын тушаалын үндсэн дээр суралцаж дууссанд тооцогдоно.

- 3.27. Төгсөлтийн шалгалт (улсын шалгалт) өгөөгүй буюу төгсөлтийн шалгалтад (улсын шалгалт) хангалтгүй дүн авсан, мөн түүнчлэн сургалтын хөтөлбөрийн хагасыг нь үзэж судалсан болон (буюу) байгууллагаас халагдсан хүмүүст Их сургуулиас бие даан тогтоосон загварын дагуу суралцсан тухай буюу суралцсан хугацааны талаар магадлагаа олгоно.

- 3.28. Төгсөлтийн лсын шалгалт өгөөгүй буюу төгсөлтийн улсын шалгалтад хангалтгүй дүн авсан суралцагчид зохих сургалтын хөтөлбөрүүдээр төгсөлтийн улсын шалгалт явуулах журамд заасан хугацаанд төгсөлтийн улсын шалгалт өгөх эрхтэй.

- 3.29. Их сургуулийн төгсөгч болон Их сургууль төгсөхөөс өмнө гарсан суралцагчид түүнийг оюутнаар бүртгэхэд үндэслэл болгосон боловсролын гэрчилгээг хувийн хэргээс нь гаргаж өгнө. Уг баримт бичгийн баталгаажуулсан хуулбар хувийн хэрэгт үлдэнэ. Бусад бүх баримт бичгүүд (сургуульд элсүүлэн авсан, төгссөн буюу




UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

хасагдсан тухай тушаалууд, дүнгийн дэвтэр, оюутны үнэмлэх болон бусад) хувийн хэрэгт хадгаладана.

4. ИХ СУРГУУЛИЙН ШИНЖЛЭХ УХААН, ТУРШИЛТ БОЛОН ИННОВАЦЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 4.1. Шинжлэх ухааны салбарт Их сургуулийн үндсэн зорилтууд нь хавсарга шинжлэх ухааны судалгаанууд явуулах, сургалтад шинжлэх ухааны хамгийн сүүлийн үеийн ололтууд болон технологиудыг ашиглах, хавсарга судалгаануудын үр дүнгүүд дээр тулгуурлан инновацын төслүүдийг хэрэгжүүлэх, суралцагчдын мэргэжлийн бэлтгэлийн түвшинг дээшлүүлэх явдал мөн.
- 4.2. Их сургуулийн шинжлэх ухааны үйл ажиллагаа нь дараах зарчмуудад үндэслэж байгаа болно:
- Их сургуулийн шинжлэх ухааны чиглэлүүдийг бий болгох, хадгалах ба хөгжүүлэх,
 - Шинжлэх ухааны судалгаанууд болон сургалтын үйл явцын уялдаа холбоог хангах,
 - Шинжлэх ухааны хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдээр хавсарга судалгаанууд болон туршилт-зохион бүтээх ажлыг хөхиүлэн дэмжих,
 - Улс орны нийгэм-эдийн засгийн үр нөлөөтэй хөгжлийн чиглэлүүдээр бусад их дээд сургуулиуд, бүс нутгийн болон холбооны байгууллагууд, шинжлэх ухааны байгууллагууд, улсын шинжлэх ухааны академиудтай хамтран шинжлэх ухааны хөтөлбөрүүд боловсруулах болон хэрэгжүүлэх,
 - Шинжлэх ухааны судалгаануудыг боловсон хүчнээр хангах, дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн дагуу суралцагчдын бэлтгэлийн чанарыг дээшлүүлэх, суралцагчдыг эрдэм шинжилгээний ажилтнуудын удирдлага дор шинжлэх ухааны судалгаа хийх ажилд татан оролцуулах, боловсролын үйл ажиллагаанд шинэ мэдлэг болон шинжлэх ухаан техникийн ололтуудыг ашиглах зорилгоор дээд боловсрол дахь боловсролын болон шинжлэх ухааны (эрдэм шинжилгээний) үйл ажиллагааг интеграцчилах.
- 4.3. Дээд боловсрол дахь боловсрол, шинжлэх ухааны (эрдэм шинжилгээний) үйл ажиллагааны интеграцыг Их сургуулиас янз бүрийн хэлбэрээр хэрэгжүүлж байж болно, тухайлбал:
- Тэтгэлэг буюу санхүүгийн бусад эх үүсвэрүүдийн тусламжтайгаар шинжлэх ухааны судалгаа болон туршилтын ажлуудыг хийж гүйцэтгэх,
 - Шинжлэх ухааны (эрдэм шинжилгээний) үйл ажиллагаа явуулдаг шинжлэх ухааны болон бусад байгууллагуудын ажилтнуудыг гэрээний үндсэн дээр боловсролын болон (буюу) шинжлэх ухааны (эрдэм шинжилгээний) үйл ажиллагаанд татан оролцуулах,
 - Шинжлэх ухааны (эрдэм шинжилгээний) үйл ажиллагаа явуулдаг шинжлэх ухааны болон бусад байгууллагууд дээр хамтрассан шинжлэх ухаан-боловсролын төслүүд, шинжлэх ухааны судалгаа болон туршилтын ажлууд, мөн түүнчлэн өөр бусад хамтарсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх,




UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Боловсролын салбарт төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтоосон журмын дагуу шинжлэх ухааны (эрдэм шинжилгээний) үйл ажиллагаа болон (буюу) шинжлэх ухаан-техникийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх лабораториуд байгуулах,
 - Боловсролын салбарт төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтоосон журмын дагуу шинжлэх ухааны (эрдэм шинжилгээний) үйл ажиллагаа явуулдаг шинжлэх ухааны болон бусад байгууллагууд дээр боловсролын үйл ажиллагаа хэрэгжүүлэх тэнхимүүд байгуулах,
- 4.4. Их сургууль нь боловсролын янз бүрийн түвшинд мэргэжилтэн бэлтгэх ажлын бүрэлдэхүүн хэсэг болж байдаг шинжлэх ухааны суурь, хавсарга, эрэл хайгуулын болон бусад судалгаа шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэнэ.
- 4.5. Их сургууль нь шинжлэх ухааны үйл ажиллагааны салбарт:
- Шинжлэх ухааны судалгааны ирээдүйтэй чиглэлүүд, мөн эрдэм шинжилгээний ажлуудын сэдэвчилсэн төлөвлөгөөнүүдийг боловсруулж гаргана,
 - Эрдэм шинжилгээний ажлуудын төлөвлөгөөний биелэлт, хийгдэж буй судалгаануудын шаардлагатай онолын түвшин, чанар болон практик ач холбогдолтой байдлыг хангана,
 - Зохих сангуудын үйл ажиллагаа болон улсын, орон нутгийн болон арилжааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төсөл, тэтгэлгийн уралдаант сонгон шалгаруулалтуудад идэвхтэй оролцоно,
 - Түр хугацаагаар уран бүтээлийн нэгдлүүд (ажилтнууд, оюутнууд, аспирантууд болон бусад хүмүүсээс бүрдсэн) байгуулах, үүний дотор мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу иргэний эрхзүйн гэрээний үндсэн дээр өөр бусад хуулийн этгээдүүд болон хувь хүмүүсийг татан оролцуулах замаар байгуулна,
 - Шинжлэх ухааны болон боловсролын үйл ажиллагааны интеграцыг хангана,
 - Их сургуулийн хийсэн шинжилгээ судалгаа, туршилтуудын үр дүнг практикт хэрэглэх талаар холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагууд, Оросын Холбооны Улсын субъектуудын төрийн захиргааны байгууллагууд, орон нутгийн захиргааны байгууллагууд, өмчийн бүхий л хэлбэрийн байгууллагуудад тогтоосон журмын дагуу шаардлагатай гэсэн шинжлэх ухаан-арга зүйн туслалцааг үзүүлнэ.
 - Иргэний эрхзүйн гэрээний үндсэн дээр өөр бусад хуулийн этгээдүүд болон хувь хүмүүсийн захиалгаар шинжилгээ судалгааны болон туршилтын ажлууд хийж гүйцэтгэнэ.
 - Шинжлэх ухааны хамгийн сүүлийн үеийн ололтуудыг түгээх болон эрдэм шинжилгээний бүтээлүүд, монографи, шинжлэх ухааны тогтмол хэвлэл болон номзүйн товхимлууд, үүний дотор Их сургуулийн шинжлэх ухааны үйл ажиллагааны үр дүнг агуулсан бүтээлүүдийг хэвлэнэ.
 - Өөрийн эрдэм шинжилгээний, мэдээлэл-тооцооллын болон материал техникийн баазыг хангаж бэхжүүлэх,



UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Шинжлэх ухаан техникийн тулгамдсан асуудлуудаар олон улсын, бүсийн болон их сургуулийн хэмжээний шинжлэх ухаан-практикийн бага хурлууд зохион явуулж, шинжлэх ухааны зарим чиглэлүүдээр тогтмол ажиллагаатай аргагүйн семинарууд, видео конференциудыг зохион байгуулна.
- 4.6. Их сургуулийн оюуны өмчийн объектуудыг эзэмших эрхүүд Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулагдана.
- 4.7. Эрдэм шинжилгээний үйл ажиллагааны санхүүжилтийг Их сургуулийн зүгээс улсын даалгаврын дагуу төрийн үйлчилгээ (ажлын хөлс) үзүүлэхтэй холбогдсон зардлуудыг нөхөхөд зориулж холбооны төсвөөс олгох тэтгэмж, төсвийн бус орлогын эх үүсвэрүүд, тэтгэлэг болон Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрүүдээс хангана.
- 4.8. Их сургуулийн шинжлэх ухааны болон (буюу) шинжлэх ухаан техникийн үйл ажиллагаа, боловсролын үйл ажиллагаатай түүний уялдаа холбоог Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу эрх бүхий зохих байгууллагууд үнэлнэ.
Их сургуулийн шинжлэх ухааны болон (буюу) шинжлэх ухаан техникийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний дүнгүүд нь улсын магадлан итгэмжлэл хийлгэх үед түүнд өгөх ерөнхий үнэлгээний нэг хэсэг байна.
- 4.9. Боловсролын салбар дахь туршилтын болон инновацын үйл ажиллагааг боловсролын системг шинэчлэх болон хөгжүүлэх зорилгоор Оросын Холбооны Улсын нийгэм-эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэлүүд, Оросын Холбооны Улсын боловсролын салбар дахь төрийн бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг харгалзан хэрэгжүүлнэ.
- 4.10. Туршилтын үйл ажиллагаа нь боловсролын шинэ технологиуд, сургалтын нөөц боловсруулан гаргаж, турших болон нэвтрүүлэхэд чиглэгдэх бөгөөд Оросын Холбооны Улсын Засгийн газраас тогтоосон журам, нөхцөлүүдийн дагуу туршилтын хэлбэрээр хэрэгжинэ.
- 4.11. Их сургуулийн инновацын үйл ажиллагаа нь боловсролын системн эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх, сургалт-аргазүйн, зохион байгуулалтын, эрхзүйн, санхүү-эдийн засгийн, боловсон хүчний, материал техникийн хангамжийг боловсронгуй болгоход чиглэгдэх бөгөөд инновацын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар хэрэгжинэ. Инновацын төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх үед боловсролын харилцаанд оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзсан, холбооны боловсролын улсын стандарт, холбооны улсын шаардлагууд, боловсролын стандартаар тогтоосон шаардлагын хэмжээнээс доогуургүй түвшний болон чанартай боловсрол олгох ба олж авах явдлыг хангасан байна.

5. ИХ СУРГУУЛИЙН УДИРДЛАГА

- 5.1. Их сургууль нь автономит байдалтай бөгөөд өөрийн үйл ажиллагааны төлөө суралцагч нэгбүрийн, нийгмийн болоод улсын орны өмнө хариуцлага хүлээнэ. Их сургуулийн автономит байдал гэдгийн дор холбооны хуулиуд, Оросын Холбооны Улсын бусад хууль-эрхзүйн актууд болон энэхүү Дүрмийн дагуу боловсролын, шинжлэх ухааны, захиргааны, санхүү-эдийн засгийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, дотоод хууль дүрэм журмаа боловсруулж баталхад түүний бие даасан байдлыг ойлгоно.



Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

Unenbat
UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

5.2. Их сургуулийн удирдлага нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомж, энэхүү Дүрмийн дагуу нэгдмэл болон хамтын удирдлагын зарчмуудыг хослуулсны үндсэн дээр хэрэгжинэ.

5.3. Их сургууль болон Үүсгэн байгуулагчийн хооронд үүсэх харилцааг Оросын Холбооны Улсын хууль тогтоомж, энэхүү Дүрмээр зохицуулна.

5.4. Их сургуулийн дүрэм, түүнд оруулах нэмэлт болон (буюу) өөрчлөлтүүдийг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу Үүсгэн байгуулагч баталгаажуулна.

Их сургууль нь бүх ажилтнууд, суралцагчид, насанд хүрээгүй суралцагчдын эцэг эхчүүдэд (хууль ёсны төлөөлөгчид) энэхүү Дүрэмтэй танилцах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Их сургуулийн Дүрэм, түүнд оруулах нэмэлт болон (буюу) өөрчлөлтүүдийг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу бүртгүүлсэн байх ёстой.

5.5. Их сургуулийн цорын ганц гүйцэтгэх засаглал нь Захирал байх бөгөөд Их сургуулийн үйл ажиллагааны өдөр тутмын удирдлагыг хэрэгжүүлнэ.

5.6. Их сургуульд хамтын удирдлагын байгууллагууд байгуулагдсан байх бөгөөд тэдгээрт Их сургуулийн ажилтан, суралцагчдын бага хурал (цаашид Бага хурал гэх), Эрдмийн зөвлөл, Удирдах зөвлөл болон үйл ажиллагааны янз бүрийн чиглэл бүхий бусад зөвлөлүүд багтана. Зөвлөл байгуулах журам, тэдгээрийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрх, шийдвэр гаргах журам болон зөвлөлүүдийн үйл ажиллагаатай холбогдсон бусад асуудлуудыг Их сургуулийн Эрдмийн зөвлөлөөс батлан гаргасан дүрэм журмаар тогтооно.

Их сургуулийн удирдлагын асуудлаар суралцагчид, насанд хүрээгүй суралцагчдын эцэг эхчүүд (хууль ёсны төлөөлөгчид) болон багш сурган хүмүүжүүлэгчдийн санал бодлыг хүлээн авах зорилгоор, мөн тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн дотоод дүрэм журмыг Их сургуулийн зүгээс батлан гаргах үед суралцагчид, насанд хүрээгүй суралцагчдын эцэг эхчүүд (хууль ёсны төлөөлөгчид) болон багш сурган хүмүүжүүлэгчдийн санаачилгаар Их сургууль дээр оюутны зөвлөлүүд, насанд хүрээгүй суралцагчдын эцэг эхчүүдийн (хууль ёсны төлөөлөгчид) зөвлөлүүд буюу бусад байгууллагууд байгуулагдаж, суралцагчдын болон (буюу) Их сургуулийн ажилтнуудын үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд үйл ажиллагаа явуулна.

5.7. Бага хурлын төлөөлөгчдийг сонгох журам, хурлын хэлэлцэх асуудал, Бага хурлыг хуралдуулах өдрийг Их сургуулийн Эрдмийн зөвлөлөөс батална. Ингэхдээ Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүд нийт төлөөлөгчдийн 50-иас илүүгүй хувийг эзэлж байх ёстой.

Төлөөлөгчдийн жагсаалтад буй төлөөлөгчдийн 2/3-с багагүй нь хуралд оролцсон нөхцөлд Бага хурлыг эрхзүйн чадамжтай гэж үзнэ. Бага хуралд оролцож буй төлөөлөгчдийн 50-иас дээш хувь нь дэмжсэн тохиолдолд Бага хурлын шийдвэрийг хүчинтэйд тооцно.

5.8. Бага хурал нь:

- Захирлыг сонгоно
- Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүдийг сонгоно



UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@sovon.mn

- Хөдөлмөрийн маргаан таслах комиссын бүрэлдэхүүнд орох Их сургуулийн хамт олны төлөөллийг сонгоно
- Хамтын гэрээг батална
- Хууль эрхзүйн актууд, энэхүү Дүрмийн дагуу өөрийн бүрэн эрхэд хамаарах бусад асуудлуудыг авч хэлэлцэнэ.

5.9. Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнд түүнийг даргалагч Захирал, орлогч захирлууд, ерөнхийлөгч болон Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр факультетуудын деканууд орно. Эрдмийн зөвлөлийн бусад гишүүдийг бага хурал дээр нууцаар санал хураах замаар сонгоно.

Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүдийн тоог Бага хурлын шийдвэрээр тогтооно.

Нэр дэвшүүлэх журам, Их сургуулийн бүтцийн салбарууд болон суралцагчдын төлөөллийн хэмжээ ба Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны хэм хэмжээг одоо ажиллаж буй Их сургуулийн Эрдмийн зөвлөлөөс тогтооно.

Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг Захирлын тушаалаар зарлана.

Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүн Их сургуулиас халагдах (хасагдах) тохиолдолд тэрбээр Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнээс автоматаар хасагдана.

Бага хурал нь Их сургуулийн Эрдмийн зөвлөлд түүний ажиллах хугацаанд гарсан гишүүдийн оронд өөрийн бүрэлдэхүүнд шинээр гишүүдийг сонгох эрхийг шилжүүлж болно.

5.10. Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 5 (таван) жил байна. Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохоос хоёр сарын өмнө Захирал Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинээр сонгох тухай зарлана. Сонгуулийг Их сургуулийн өмнөх Эрдмийн зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохоос өмнө явуулна.

Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүдийн сонгуулийг түүний гишүүдийн талаас доошгүй хувь нь шаардсаны дагуу хугацаанаас өмнө явуулна.

5.11. Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн тухай журмыг одоо ажиллаж буй Их сургуулийн Эрдмийн зөвлөл батална.

5.12. Их сургуулийн Эрдмийн зөвлөл нь:

- Бага хурал зарлан хуралдуулах тухай шийдвэр гаргана
- Бага хурлын төлөөлөгчдийг сонгох журмыг тогтооно
- Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх журам болон Их сургуулийн Эрдмийн зөвлөл дэх Их сургуулийн бүтцийн салбарууд болон суралцагчдын төлөөллийн хэмжээг тогтооно
- Их сургуулийн Эрдмийн зөвлөлд факультетуудын декануудыг шууд (сонгуульгүйгээр) оруулах тухай шийдвэрийг гаргана



Unenbat
UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Их сургуулийн Дүрмийн төсөл, мөн түүнчлэн Дүрэмд оруулах нэмэлт болон (буюу) өөрчлөлтүүдийг авч хэлэлцэнэ
- Их сургуулийн ажилтнууд болон суралцагчид Оросын Холбооны Улсын хууль тогтоомж болон энэхүү Дүрмийн заалтуудыг биелүүлж байгаа эсэхэд ерөнхийд нь хяналт тавина
- Их сургуулийн Захирлын сонгууль явуулах хугацаа болон журмыг тодорхойлно
- Их сургуулийн Захирлын албан тушаалд нэр дэвшүүлэх журам ба нэр дэвшигчдэд тавих шаардлагуудыг тодорхойлно
- Жил бүр Захирлын, үүний дотор хөрөнгө мөнгө орж ирсэн ба зарцуулсан тухай тайланг сонсож, батална
- Их сургуулийн эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн гол асуудлуудыг авч хэлэлцэнэ
- Холбооны төсвийн хөрөнгийн ашиглалт болон төсвийн бус санхүүгийн хөрөнгийн хуваарилалтын гол чиглэлүүдийг авч хэлэлцэнэ
- Боловсролын төлбөртэй үйлчилгээ үзүүлэх журмыг баталж гаргана
- Сургалтын, сургалт-арга зүйн, эрдэм шинжилгээний болон мэдээлэл судалгааны ажлын, боловсон хүчин бэлтгэх, Их сургуулийн гадад харилцааг хэрэгжүүлэх асуудлуудыг шийдвэрлэж, сургалтын үйл явцыг зохион байгуулах, үүний дотор суралцах хугацаатай холбогдсон асуудлаар холбооны боловсролын улсын стандартын шаардлагуудад нийцүүлэн шийдвэр гаргаж, эрдэм шинжилгээний ажлын төлөвлөгөө боловсруулах журмыг батална.
- “Доцент”, “профессор” зэрэг эрдмийн цол хэргэм олгох тухай хүсэлтийг зохих журмын дагуу гаргаж, мөн Их сургуулийн ажилтнуудыг Оросын шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүнээр сонгуулахаар санал болгоно.
- Хүндэт цол, шагнал, урамшуулалд Их сургуулийн ажилтнуудыг тодорхойлно.
- Факультетуудын деканууд, тэнхмийн эрхлэгч нарыг Дүрэмд заасан журмын дагуу сонгоно.
- Профессор, доцентын албан тушаалд нэр дэвшигчдийн дунд мөрдөгдөж буй хууль эрхзүйн актуудаар тогтоосон журмын дагуу сонгон шалгаруулалт явуулна.
- Ээлжит хичээлийн жилд суралцагчдыг Их сургуульд элсүүлэх элсэлтийн дүрмийг баталж гаргана.
- Бэлтгэлийн (мэргэжлийн) чиглэлүүд нээж, тэдгээрийг гэрчилгээжүүлэх болон магадлан итгэмжлүүлэх тухай шийдвэр гаргана.
- Их сургуулийн бүрэлдэхүүнд бүтцийн салбар нэгжүүд нээх тухай шийдвэр гаргана.
- Их сургуулийн бүтцийн салбар нэгжүүдийн тухай дүрэм журмыг авч хэлэлцэнэ.



UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Ганцаарчилсан төлөвлөгөөний дагуу суралцаалах болон түргэвчилсэн сургалт зохион байгуулах тухай журам баталж, мөн Дүрэмд заасан тохиолдлуудад зарим хүмүүст зориулан суралцах хугацааг богиносгох тухай шийдвэр гаргана.
- Дүрэмд заасан тохиолдлуудад суралцах хугацааг уртасгах тухай шийдвэр гаргана.
- Төгсөгчдийн төгсөлтийн шалгалтыг явуулах журам ба арга хэлбэрийг авч хэлэлцэнэ.
- Суралцагчдын дадлагыг зохион байгуулах тухай журмыг авч хэлэлцэнэ.
- Суралцагчдыг шилжүүлэх, хасах болон сэргээх журам ба үндэслэлүүдийг баталж гаргана.
- Сургалт болон сурган хүмүүжүүлэх бусад ажлын нийт хичээлийн жил буюу ажлын 7 хоногийн хүрээнд эзлэх хувь хэмжээг журмаар батална.
- Нэг жил хүртэл хугацаатай урт хугацааны амралт авах эрх олгох тухай шийдвэрийг сурган хүмүүжүүлэх ажил тасралтгүй эрхэлсэн 10-аас доошгүй жил тутамд Боловсролын салбарт төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтоосон журмын дагуу гаргана.
- Сурган хүмүүжүүлэх ажилтнуудын ажиллаж буй албан тушаалдаа тэнцэж буй эсэхийг тогтоох зорилгоор аттестатчилал явуулах журмыг батална.
- Боловсролын салбарт төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтоосон журмын дагуу стипендийн тухай журмыг батална.
- Суралцагчдын стипендийн хангамжид зориулж Их сургуульд хуваарилж өгсөн хөрөнгийн (стипендийн сан) хүрээнд оюутнуудын улсын хичээлийн болон улсын нийгмийн стипенди, аспирантуудын улсын стипендийн хэмжээг тогтооно.
- Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит, Оросын Холбооны Улсын Засгийн газрын нэрэмжит болон бусад нэрэмжит стипенди олгох талаар хүсэлт тавина.
- Их сургуулийн оюутнууд болон аспирантуудад нэрэмжит стипенди олгох болсныг баталгаажуулна.
- Их сургуулийн хэмжээнд суралцагчдад нийгмийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ болон материаллаг туслалцаа үзүүлэх журмыг авч хэлэлцэнэ.
- Их сургуулийн Удирдах зөвлөл байгуулах тухай шийдвэр гаргана.
- Их сургуулийн Удирдах зөвлөлийн тухай журмыг батална.
- Бүтцийн салбар нэгжүүдэд сонгуульт төлөөллийн байгууллагууд болох эрдмийн зөвлөлүүд (зөвлөлүүд) байгуулах тухай шийдвэр гаргана.
- Бүтцийн салбар нэгжүүдэд эрдмийн зөвлөлүүд (зөвлөлүүд) байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаа, бүрэлдэхүүн болон бүрэн эрхийн тухай журам батална.



Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын зөвлөлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn


UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

- Оросын Холбооны Улсын хүндэт цол олгох, төрийн болон салбарын шагнал, урамшуулалд тодорхойлох хүсэлт гаргана.
 - Их сургуулийн хүндэт цол хэргэм олгоно.
 - Онцгой эрхийг нь Их сургууль эзэмшиж буй оюуны үйл ажиллагааны үр дүнгүүдийг (цахим тооцоолон бодох машины програм хангамж, өгөгдлийн сангууд, ашигтай загвар, бүтээл, аж үйлдвэрийн загвар, интеграль бичил схемын топологи, үйлдвэрлэлийн нууц (ноу хау)) практикт хэрэглэх (нэвтрүүлэх) үйл ажиллагаа эрхэлсэн аж ахуйн байгууллага (үүний дотор бусад этгээдүүдтэй хамтран) байгуулах тухай шийдвэр гаргана.
 - Их сургуулийн диссертацийн зөвлөлүүдийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлуудыг авч хэлэлцэнэ.
 - Төгсөгчдийн жилийн эцсийн шалгалт, жилийн эцсийн улсын шалгалтыг явуулах журам ба арга хэлбэрүүдийг авч хэлэлцэнэ.
 - Оросын Холбооны Улсын хууль тогтоомж болон Их сургуулийн Дүрэм, Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн тухай журамд заасан бусад бүрэн эрхүүдийг хэрэгжүүлнэ.
- 5.13. Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрт түүний даргын хувьд Захирал, мөн уг зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.
- Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн хуралдаанд болон түүний авч хэлэлцэж буй асуудлын хэлэлцүүлэгт ОХУ-ын ХААЯ-ны төлөөлөгчид, Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүн бус ажилтнууд болон суралцагчид оролцож болно.
- 5.14. Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн шийдвэр нь түүний бүрэлдэхүүний 2/3-с доошгүй гишүүд хуралдаанд оролцсон нөхцөлд эрхзүйн чадамжтай болно. Шийдвэрийг биеэр оролцож буй Эрдмийн зөвлөлийн гишүүдийн 50-иас дээш хувь нь дэмжсэн нөхцөлд батлагдсанд тооцно.
- 5.15. Эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх ажилтны албан тушаалын сонгон шалгаруулалт, факультетуудын деканууд, тэнхмийн эрхлэгч нарын сонгуулийн үр дүнгийн талаар болон эрдмийн зэрэг цолонд тодорхойлох асуудлаар нууцаар санал хурааж шийдвэр гаргана. Бусад шийдвэрийг гаргахад санал хураалтыг нээлттэй явуулна.
- 5.16. Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрүүдийг хурлын тэмдэглэл дагалдах бөгөөд, хэрэв Эрдмийн зөвлөлийн шийдвэрт өөрөөр заагаагүй бол, батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 5.17. Эрдмийн зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гаргасан Эрдмийн зөвлөлийн шийдвэрүүд нь Их сургуулийн нийт ажилтан, суралцагчдын хувьд заавал биелүүлэх шийдвэр байна.
- 5.18. Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн хуралдаанууд нь ихэнхдээ хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөний дагуу явагдана. Дараачийн хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөг Их сургуулийн Эрдмийн зөвлөл энэ хичээлийн жилийн төгсгөлд авч хэлэлцэн Захирлаар батлуулна.
- 5.19. Их сургуулийн Захирал нь Их сургуулийн Бага хурлаар сонгогдох бөгөөд улмаар Их сургуулийн Үүсгэн байгуулагч батална. Захирлын албан тушаалд нэр дэвшигчид нь дээд боловсролтой бөгөөд боловсролын байгууллагын зохих



UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

удирдах албан тушаалтнуудад тавигдах мэргэжлийн лавлахад заасан мэргэжлийн ур чадварын шаардлагуудыг хангаж байх ёстой.

Их сургуулийн Захирлын албан тушаалд нэр дэвшигчид нь заавал аттестатчилалд орно. Их сургуулийн Захирлын албан тушаалд нэр дэвшигчдийг аттестатчилах журам ба хугацааг Их сургуулийн Үүсгэн байгуулагч тогтооно.

- 5.20. Их сургуулийн Захирлын сонгууль явуулах журам болон үйл ажиллагаа, Захирлын албан тушаалд нэр дэвшүүлэх журам ба тэдгээрт тавигдах шаардлагуудыг Оросын Холбооны Улсын хууль тогтоомж болон энэхүү Дүрмээр тодорхойлно. Захирлын албан тушаалд нэр дэвшүүлэх журамд бие даан нэрээ дэвшүүлэхээр заасан байх ёстой.
- 5.21. Их сургуулийн Захирлын албан тушаалд нэр дэвшигчдийг мэргэжлийн өндөр ур чадвар бүхий эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх ажилтнуудаас буюу эрдмийн зэрэг болон эрдмийн цолтой мэргэжилтнүүдээс нэр дэвшүүлж, улмаар ОХУ-ын ХААЯ-ны аттестатчиллын комиссоор хэлэлцүүлэхээр оруулна.
- 5.22. Захирлын сонгууль явуулах тухай Бага хурал хуралдуулах товыг ОХУ-ын ХААЯ-тай зөвшилцөнө.

- 5.23. Захирал нь Их сургуулийн Эрдмийн зөвлөлөөс баталсан "Захирлын сонгуулийн журам"-ыг үндэслэн Бага хурлаар ирц бүрдсэн нөхцөлд (нийт сонгогдсон төлөөлөгчдийн 2/3-с доошгүй) ОХУ-ын ХААЯ-ны аттестатчиллын комисстой зөвшилцсөн нэр дэвшигчдийн дундаас нууц санал хураалтаар 5 (таван) жилийн хугацаатай сонгогдох бөгөөд Бага хуралд оролцож буй төлөөлөгчдийн 50-иас дээш хувийн саналыг авсан тохиолдолд сонгогдсон тооцогдоно.

Хэрэв эхний шатанд нэр дэвшигчдийн хэн нь ч шаардлагатай тооны санал авч чадаагүй бол эхний шатанд хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигч дээр завсарлага авалгүйгээр тэр өдрөө дахин санал хураалт явуулна. Хоёр дахь шатанд ердийн олонхийн саналыг авч чадсан нэр дэвшигч сонгогдсон тооцогдоно.

Захирлыг сонгосны дараагаар захирал болон ОХУ-ын ХААЯ-ны хооронд 5 (тав) хүртэл жилийн хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулна.

Захирлын давтан сонгуулийг Оросын Холбооны Улсын хууль тогтоомж болон Их сургуулийн Дүрмээр тогтоосон Захирал сонгох үйл ажиллагааг зөрчсөн, эсхүл Захирлын сонгуулийг бүтэлгүйтсэн буюу хүчингүйд тооцсон тохиолдолд явуулна.

- 5.24. Захирлын эрх үүрэг, мөн түүнчлэн түүнтэй үүсэх хөдөлмөрийн харилцааг цуцлах үндэслэлүүд нь Захирал болон ОХУ-ын ХААЯ-ны хооронд Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу 5 (тав) хүртэл жилийн хугацаатай байгуулагдах хугацаат хөдөлмөрийн гэрээгээр зохицуулагдана.

- 5.25. Их сургуулийн Захирлын албан тушаалыг хөдөлмөрийн гэрээний хүчинтэй хугацааг харгалзахгүйгээр 65 хүртэлх насны этгээдээр орлуулна.

Их сургуулийн Эрдмийн зөвлөлөөс санал болгосны дагуу Их сургуулийн Үүсгэн байгуулагч нь Захирлын албан тушаалдаа байх хугацааг, хэрэв Оросын Холбооны Улсын хөдөлмөрийн хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол, 70 нас хүртэл нь сунгаж болно.

- 5.26. Захирлын албан тушаалын ажил үүргүүдийг давхар гүйцэтгэж байж болохгүй.




UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

5.27. Захиралтай байгуулсан хугацаат хөдөлмөрийн гэрээг өөрчлөх болон цуцлахдаа Оросын Холбооны Улсын хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан журмыг баримтална.

5.28. Захирлын албан тушаал сул байх тохиолдолд Захирлын үүрэг гүйцэтгэх этгээдийг ОХУ-ын ХААЯ-наас томилно.

5.29. Захирал нь Оросын Холбооны Улсын хуулиуд болон хууль эрхзүйн бусад актууд, энэхүү Дүрэм болон түүнтэй байгуулсан хугацаат хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр Их сургуулийн нэрийн өмнөөс ямар нэг итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах бөгөөд, түүний эрх ашгийг Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэрт болон хилийн чанадад үнэнч шударгаар, бодлоготойгоор төлөөлнө.

Захирал нь дангаар үйл ажиллагаа явуулах зарчмаар ажиллах бөгөөд өөрийн үйлдлүүдийн үр дагаврын төлөө хариуцлагыг Оросын Холбооны Улсын хуулиуд болон хууль эрхзүйн бусад актууд, энэхүү Дүрэм болон түүнтэй байгуулсан хугацаат хөдөлмөрийн гэрээний дагуу хүлээнэ.

5.30. Захирал нь Бага хурал болон Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн бүрэн эрхэд хамаарахаас бусад Их сургуулийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л асуудлаар шийдвэр гаргаж, дараах үүргүүдийг гүйцэтгэнэ:

- Их сургуулийн эд хөрөнгийг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу захиран зарцуулж, харьяаллын дагуу Холбооны санхүүгийн байгууллагуудад холбооны төсвийн хөрөнгө болон ашиг орлого бүхий үйл ажиллагаанаас олсон хөрөнгийг бүртгэх зорилгоор Оросын Холбооны Улсын үндэсний валютын харилцах данснууд, ОХУ-ын Төв Банк болон зээлийн байгууллагуудад гадаад валютын данснуудыг Оросын Холбооны Улсын валютын тухай хууль тогтоомжийн дагуу нээнэ.
- Өөрийн бүрэн эрхийн хүрээнд Их сургуулийн нийт ажилтнууд болон суралцагчдын заавал биелүүлэх дотоод хууль эрхзүйн актуудыг (тушаал болон шийдвэр) гаргаж, заавар өгнө.
- Их сургуулийн бүтцийг тодорхойлж, Их сургуулийн ажилтнуудын ажлын цагийн хуваарийг баталж, ажилтан ажилд авч, мөн халах бөгөөд албан тушаалд сонгох сонгуулийн болон зохих албан тушаалыг орлуулах тохиолдолд сонгон шалгаруулалтын үр дүнд албан тушаалд сонгогдсон, албан тушаалд томилогдсон буюу албан тушаалд батлагдсан болон Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан бусад тохиолдлуудад тэдгээртэй хөдөлмөрийн гэрээ байгуулан, ажилтнуудтай байгуулах хөдөлмөрийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулан, хөдөлмөрийн гэрээг цуцалж, тэдгээрийн эрх, үүрэг болон хариуцлагыг тодорхойлно.
- Улсын нууцыг хамгаалах ажлууд зохион байгуулах болон нөхцөл бүрдүүлэх асуудлыг өөрийн биеэр хариуцаж, хууль тогтоомжоор улсын нууцад хамаарах мэдээлэлтэй танилцуулахтай холбогдуулан тогтоосон хязгаарлалтуудыг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээнэ.
- Үйлдвэрчний эвлэлийн хороо болон ажилтнуудын санал бодлыг харгалзсаны үндсэн дээр хөдөлмөрийн дотоод дүрмийг батална.
- Их сургуулийн салбар нэгжүүдийн удирдлагуудын бүрэн эрхийн хүрээ, үүрэг болон хариуцлагыг тодорхойлно.



Unenbat
UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Их сургуулийн дотоод хууль эрхзүйн актууд болон Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор тогтоосон сахилгын арга шийтгэлүүдийг бүх ажилтнууд болон оюутнуудад хүлээлгэнэ.
- Их сургуулийн нэрийн өмнөөс хамтын гэрээнд гарын үсэг зурна.
- Жил бүр Их сургуулийн Эрдмийн зөвлөл дээр Их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ болон санхүүгийн үйл ажиллагааны талаар тайлагнана.
- Их сургуулийн олон улсын болон эдийн засгийн гадаад үйл ажиллагаатай холбогдсон гол гол асуудлуудаар шийдвэр гаргана.
- Их сургуулийн салбар нэгжүүдийн талаарх дүрэм журам болон Оросын Холбооны Улсын хууль тогтоомж болон энэхүү Дүрмийн заалтуудтай харшлахгүй дотоод хууль эрхзүйн бусад актуудыг батална.
- Байгуулсан хөдөлмөрийн гэрээний дагуу Их сургуулийн үйл ажиллагааг зохион байгуулах болон хангахтай холбогдсон бусад үүргүүдийг хэрэгжүүлнэ.

5.31. Захирал нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомж, Их сургуулийн Дүрмийн шаардлагуудын дагуу дараах зүйлсийг хариуцна:

- Холбооны төсвийн хөрөнгө болон ашиг орлого бүхий үйл ажиллагаанаас олох хөрөнгийн Оросын Холбооны Улсын хууль тогтоомж, Их сургуулийн Дүрмээр тогтоосон журмын дагуу ашиглалт,
- Их сургуулийн тусгай зөвшөөрөлд заасан боловсролын үйл ажиллагааны нөхцөл болзлуудын биелэлт, Их сургуулийн төгсөгчдийн боловсролын чанарын талаар тогтоосон холбооны боловсролын улсын стандартууд, холбооны улсын шаардлагуудын хангалт,
- Их сургуулийн ажилтнууд болон суралцагчдад стипенди, цалин хөлс, нэмэгдэл болон бусад төлбөрийг цаг тухайд нь олгох явдал,
- ОХУ-ын ХААЯ-наас Их сургуулийн удирдлагын үйл ажиллагаанд хүлээлгэн өгсөн эд хөрөнгийн Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу хамгаалалт болон ашиглалт,
- Холбооны хөтөлбөрүүдээр батлагдсан улсын хэрэгцээнд ажил гүйцэтгэх болон үйлчилгээ үзүүлэх тухай гэрээнүүдийн Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдах явдал, мөн Их сургуулийн гэрээгээр хүлээсэн үүргүүдийн биелэлт.
- Их сургуулийн ажилтнуудтай байгуулсан хамтын гэрээний нөхцөлүүдийн биелэлт,
- Их сургуулийг эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх, инженер техникийн, сургалтын туслах болон бусад төрлийн мэргэжлийн ажилтнуудаар хангах явдал,
- Их сургуулийн санхүү-аж ахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх,
- Улсын нууцыг хамгаалах ажлын зохион байгуулалт болон нөхцөл бүрдүүлэх, хууль тогтоомжоор улсын нууцад хамаарах мэдээлэлтэй танилцуулахтай холбогдуулан тогтоосон хязгаарлалтуудын зөрчил,




UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Их сургуулийн ажилтнуудын хөдөлмөр хамгааллын дүрэм болон эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон шаардлагуудын биелэлт, мөн түүнчлэн Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн байгаль орчны талаарх шаардлагуудын биелэлтийг хангах.
 - Иргэний хамгаалалтын шаардлагуудын биелэлтийг хангах.
- 5.32. Дэд захирлууд болон бусад удирдах ажилтнуудын ажил үүргийн хуваарийг Их сургуулийн захирлын тушаалаар тогтоож улмаар Их сургуулийн нийт хамт олонд мэдээлнэ.
- 5.33. Дэд захирлуудыг хугацаат хөдөлмөрийн гэрээгээр ажилд авах бөгөөд гэрээний дуусгавар болох хугацаа Их сургуулийн Захирлын бүрэн эрхийн хугацаанаас илүүгүй байна. Дэд захирлуудын тоо болон тэдгээрийн ажил үүргийн хуваарийг Их сургуулийн Захирал тогтоож өгнө.
- 5.34. Дэд захирлууд, Их сургуулийн салбарын захирлуудын албан тушаалыг хөдөлмөрийн гэрээний хугацаанаас үл хамааран 65 хүртэл насны хүмүүсээр орлуулна. Дээр дурдсан албан тушаал дээр байгаа 65 нас хүрсэн хүмүүсийг бичгээр гаргасан зөвшөөрлийнх нь дагуу тэдний мэргэжлийн ур чадварт тохирсон өөр албан тушаалд шилжүүлнэ.
- Захирал нь Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн санал болгосны дагуу дэд захирал, Их сургуулийн салбарын захирлын албан тушаал дээрээ байх хугацааг тэднийг 70 нас хүртэл сунгах эрхтэй.
- 5.35. Их сургуульд ОХУ-ын ХААЯ-наас урьдчилан зөвшөөрөл авсны дагуу Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр Их сургуулийн Ерөнхийлөгчийн албан тушаалыг бий болгож болно. Их сургуулийн Ерөнхийлөгчийн албан тушаалыг орлож буй этгээд нь Их сургуулийн Захирлын албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан ажлын туршлагатай байх ёстой. Захирал болон Их сургуулийн Ерөнхийлөгчийн албан тушаалыг хавсран гүйцэтгэж байж болохгүй.
- 5.36. Их сургуулийн Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг ОХУ-ын ХААЯ-наас Эрдмийн зөвлөлд оруулна. Их сургуулийн Ерөнхийлөгчийг Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар нууцаар санал хурааж, ердийн олонхийн санаар сонгоно. Сонгогдсон Ерөнхийлөгч нь уг албан тушаалд ОХУ-ын ХААЯ-ны тушаалаар батлагдаж, улмаар 5 (тав) хүртэл жилийн хугацаатай хөдөлмөрийн гэрээг байгуулна. Их сургуулийн Ерөнхийлөгчтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан үндэслэлүүд, мөн түүнчлэн Их сургуулийн Захиралтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ цуцлагдах үндэслэлүүдээр цуцална.

Их сургуулийн Ерөнхийлөгч нь Их сургуулийн Захиралтай зөвшилцсөний дагуу дараах бүрэн эрхүүдийг хэрэгжүүлнэ:

- Удирдах зөвлөл болон Их сургуулийн өөрөө удирдах бусад байгууллагуудын үйл ажиллагаанд оролцоно.
- Их сургуулийн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулахад оролцоно.
- Төрийн байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллагууд, олон нийтийн болон бусад байгууллагуудтай харилцах үед Их сургуулийг төлөөлнө.




UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, хүмүүжлийн, зохион байгуулалтын болон удирдлагын үйл ажиллагааг боловсронгуй болгохтой холбогдсон асуудлуудыг шийдвэрлэхэд оролцоно.

Их сургуулийн Захирлын баталсан журмын дагуу Их сургуулийн үйл ажиллагааг зохион байгуулах болон хангахтай холбогдсон бусад үүргүүдийг гүйцэтгэнэ.

- 5.37. Факультетыг Их сургуулийн Эрдмийн зөвлөлөөс факультетын эрдмийн зөвлөлийн санал болгосны дагуу мэргэжлийн дээд боловсролтой, эрдэм шинжилгээний буюу эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх ажлын 5-аас доошгүй жилийн туршлагатай, эрдмийн зэрэг буюу эрдмийн цол бүхий Их сургуулийн мэргэжлийн хамгийн өндөр ур чадвартай гэсэн ажилтнуудын дотроос факультетын тухай журмын дагуу 5 хүртэл жилийн хугацаатай сонгогдох декан удирдана.

Деканы албан тушаалд нэр дэвшүүлэх ажлыг тэнхимүүд болон факультетын бүтцийн салбар нэгжүүд хэрэгжүүлнэ. Деканы албан тушаалд нэр дэвшүүлэх журмыг факультетын тухай зохих журмаар тогтооно.

Сонгогдсон декантай хугацаат хөдөлмөрийн гэрээ байгуулагдана.

Декан нь факультетын сургалтын болон эрдэм шинжилгээний үйл ажиллагаа, аргазүйн хангалт, оюутнуудын хүмүүжил, факультетын боловсон хүчний бодлогын салбар дахь зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. Декан нь факультетын үйл ажиллагааны үр дүнгийн төлөө өөрийн биеэр хариуцлага хүлээнэ.

- 5.38. Тэнхимийг Их сургуулийн Эрдмийн зөвлөлөөс тэнхимийн санал болгосноор тухайн мэргэжлээр хамгийн өндөр ур чадвартай, мэргэжлийн дээд боловсролтой, эрдмийн зэрэг буюу эрдмийн цол бүхий, эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх ажлын буюу мэргэжлийн чиглэлийн болон тэнхимийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу байгууллагуудад 5-аас доошгүй жил ажилласан мэргэжилтнүүдийн дотроос нууц санал хураалтаар тэнхимийн тухай журмын дагуу 5 хүртэл жилийн хугацаатай сонгогдох эрхлэгч удирдана.

Сонгогдсон тэнхимийн эрхлэгчтэй хугацаат хөдөлмөрийн гэрээ байгуулагдана. Тэнхимийн эрхлэгчийг сонгох журмыг Захирлын баталсан Их сургуулийн дотоод дүрэм журмын дагуу тогтооно.

Тэнхимийн эрхлэгч нь тэнхимийн сургалт, сургалт-аргазүйн болон эрдэм шинжилгээний ажлын түвшин, үр дүнгийн төлөө өөрийн биеэр хариуцлага хүлээнэ.

- 5.39. Их сургуулийн салбарууд (цаашид Салбар гэх) нь их дээд сургуулийн бүхий л үүргүүдийг бүхэлд нь буюу хэсэгчлэн байнга гүйцэтгэнэ.

Салбарын үйл ажиллагааны шууд удирдлагыг Их сургуулийн Захирлын олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж буй захирал хэрэгжүүлнэ. салбарын захирал нь Их сургуулийн Захирлын тушаалаар уг албан тушаалд томилогдож мөн чөлөөлөгдөнө.

- 5.40. Их сургуулийн удирдлага дахь суралцагчдын оролцоо нь Их сургуулийн Эрдмийн зөвлөл, факультетуудын эрдмийн зөвлөл, салбаруудын зөвлөлүүдийн бүрэлдэхүүнд, суралцагчдын олон нийтийн байгууллагуудад сонгогдох боломжоор дамжин хангагдана.



Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@sovon.mn


UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

6. СУРАЛЦАГЧИД БА ИХ СУРГУУЛИЙН АЖИЛТНУУД

6.1. Их сургуульд суралцагчдад (боловсролын хөтөлбөр эзэмшиж буй хувь хүмүүс) оюутнууд, аспирантууд, сонсогчид, экстернууд болон Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан бусад хүмүүс хамаарна.

Оюутан гэдэг нь мэргэжлийн дунд боловсролын хөтөлбөр, бакалаврын хөтөлбөр, мэргэшүүлэх хөтөлбөр буюу магистрын сургалтын хөтөлбөрийг судалж буй этгээд болно.

Аспирант гэдэг нь эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх боловсон хүчин бэлтгэх хөтөлбөрийн дагуу аспирантурт суралцаж буй этгээд болно.

Сонсогч гэдэг нь мэргэжлийн нэмэлт хөтөлбөрүүдийг судалж буй этгээд, мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдийг судалж буй этгээд, мөн түүнчлэн, хэрэв мөрдөгдөж буй хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол, Их сургуулийн бэлтгэл салбарт суралцахаар элсэн орсон этгээд болно.

Экстерн гэдэг нь улсаас магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрүүдээр завсрын болон төгсөлтийн улсын аттестатчилал өгөх зорилгоор Их сургуульд элсэн орсон этгээд болно.

6.2. Суралцагчдад дараах эрхүүдийг олгоно:

- Боловсролын үйл ажиллагаа явуулж буй байгууллага, боловсрол олж авах хэлбэр болон үндсэн ерөнхий боловсрол олж авсны дараагаар буюу 18 нас хүрсний дараагаар суралцах хэлбэрийг сонгох.
- Бие бялдар-сэтгэцийн хөгжил болон эрүүл мэндийн байдлын онцлогийг харгалзсан суралцах нөхцөл бүрдүүлэх, мөн нийгэм-сурган хүмүүжүүлэхийн болон сэтгэлзүйн туслалцаа авах, сэтгэл зүй-эмнэлэг-сурган хүмүүжүүлэхүйн үнэгүй засал хийлгэх.
- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний дагуу, үүний дотор Их сургуулийн дотоод дүрэмд заасан журмын дагуу судалж буй боловсролын хөтөлбөрийн хүрээнд түргэвчилсэн сургалтаар суралцах.
- Мэргэжлийн дунд болон дээд боловсролын холбооны боловсролын улсын стандартууд, боловсролын стандартуудыг дагаж мөрдсөн нөхцөлд Их сургуулийн дотоод дүрмээр тогтоосон журмын дагуу өөрийн мэргэжлийн боловсролын агуулгыг тодорхойлоход оролцох.
- Сонгон суралцах (тухайн боловсролын түвшин, мэргэжил, мэргэшил буюу бэлгэх чиглэлийн хувьд заавал судлах шаардлагагүй) болон заавал сонгох (заавал сонгох журмаар сонгох) хичээл, курс, салбар ухаануудыг (модуль) Их сургуулиас (үндсэн ерөнхий боловсрол олж авсны дараагаар) санал болгож буй жагсаалтаас сонгох.
- Судалж буй боловсролын хөтөлбөрийн дагуу хичээлүүд, курс, салбар ухаануудыг (модуль) судлахын зэрэгцээгээр Их сургуульд зааж буй өөр бусад дурын хичээлүүдийг тогтоосон журмын дагуу үзэж судлах, мөн боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг бусад байгууллагуудад заадаг хичээлүүд, курс, салбар ухаанууд (модуль), дадлага, нэмэлт боловсролын хөтөлбөрүүдийг үзэж судлах, хэд хэдэн үндсэн мэргэжлийн боловсролын хөтөлбөрүүдийг нэг зэрэг үзэж судлах.



UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Их сургууль нь суралцагчийн боловсролын үйл ажиллагаа эрхэлж буй бусад байгууллагуудад заадаг хичээл, курс, салбар ухаанууд (модуль), дадлага, нэмэлт боловсролын хөтөлбөрүүдийг эзэмшсэн дүнгийн үзүүлэлтийг тогтоосон журмын дагуу тооцох.
- Цэргийн албанд татагдахыг мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу хойшлуулах.
- Нэр төрөө хүндлүүлэх, биеийн болон сэтгэлзүйн аливаа хэлбэрийн хүчирхийлэл, гутаан доромжлох явдлаас хамгаалуулах, амь нас эрүүл мэндээ хамгаалуулах.
- Сүсэг бишрэл, мэдээллийн эрх чөлөө, өөрийн үзэл бодол, итгэл үнэмшлийг чөлөөтэй илэрхийлэх.
- Амралт – боловсрол олж авах хугацаанд боловсролын тухай хууль тогтоомж болон сургалтын календарчилсан төлөвлөгөөний дагуу амрах болон нийгмийн бусад зорилгоор олгодог төлөвлөгөөт завсарлагаа.
- Боловсролын салбарт төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтоосон үндэслэл болон журмын дагуу олгодог жилийн чөлөө, мөн түүнчлэн холбооны хуулиар тогтоосон журмын дагуу олгодог жирэмсний болон хүүхэд төрүүлсний дараах амралт, хүүхдээ 3 нас хүртэл асрах амралт.
- Боловсролын тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу өөр мэргэжил, мэргэшил болон (буюу) бэлгэх чиглэлээр, сургалтын өөр хэлбэрээр боловсрол олж авахаар шилжин суралцах.
- Боловсролын салбарт төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллага, Их сургуулийн дотоод дүрмээр тогтоосон үндэслэл болон журмын дагуу төлбөртэй сургалтаас төлбөргүй сургалтад шилжих.
- Боловсролын салбарт төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтоосон журмын дагуу зохих түвшний боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэгч боловсролын өөр байгууллага руу шилжин суралцах.
- Боловсролын тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу Их сургуульд боловсрол олж авах зорилгоор суралцах эрх сэргээх.
- Дүрэмд заасан журмын дагуу Их сургуулийн удирдлагад оролцох.
- Их сургуулийн зохион байгуулалт болон боловсролын үйл ажиллагааны хэрэгжүүлэлтийг зохицуулж буй улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, боловсролын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлийн гэрчилгээ, сургалтын баримт бичгүүд, бусад бичиг баримтуудтай танилцах.
- Их сургуулиас гаргасан шийдвэрийг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу давж заалдах.
- Их сургуулийн номын сан-мэдээллийн нөөц, сургалт, үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний баазыг үнэ төлбөргүй ашиглах.



UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Их сургуулийн дотоод дүрмээр тогтоосон журмын дагуу Их сургуулийн эмчилгээ-сувилгааны дэд бүтэц, соёлын болон спортын объектуудыг ашиглах.
- Уралдаан, олимпиад, үзэсгэлэн, үзлэг, биеийн тамир спортын арга хэмжээнүүд, үүний дотор спортын албан ёсны уралдаан тэмцээнүүд, мөн олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдэд оролцох замаар өөрийн авьяас чадварыг сонирхлын дагуу хөгжүүлэх.
- Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу Их сургуулиас хэрэгжүүлж буй эрдэм шинжилгээний, шинжлэх ухаан-техникийн, туршилтын болон инновацын үйл ажиллагаанд Их сургуулийн эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх ажилтнууд болон (буюу) эрдэм шинжилгээний ажилтнуудын удирдлага дор оролцох.
- Сонгосон сэдвээр суралцах болон судалгаа шинжилгээ хийх, дадлагын ажил гүйцэтгэх зорилгоор, үүний дотор мөн оюутан солилцооны хөтөлбөрийн хүрээнд, өөр бусад их дээд сургуулиуд болон эрдэм шинжилгээний байгууллагууд, үүний дотор гадаад улс орны дээд боловсролын байгууллагууд болон шинжлэх ухааны байгууллагуудад томилогдох.
- Их сургуулийн сонин хэвлэлд өөрийн бүтээлүүдийг үнэ төлбөргүй хэвлэж нийтлэх.
- Сургалтын, биеийн тамир спортын, олон нийтийн, эрдэм шинжилгээний, шинжлэх ухаан-техникийн, соёл урлагийн, туршилтын болон инновацын үйл ажиллагаанд гаргасан амжилтын төлөө шагнал урамшуулал хүртэх.
- Сургалтын хөтөлбөр эзэмших, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг биелүүлэхэд хохирол учруулахгүйгээр боловсрол олж авах явдлыг ажилтай хослуулах.
- Өөрийн эзэмшиж буй мэргэжил, мэргэшил болон бэлтгэх чиглэлээр Оросын Холбооны Улсын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн салбар дахь байдал ямар байгаа талаар Их сургуулиас мэдээлэл авах.
- Оросын Холбооны Улсын хууль тогтоомж, Их сургуулийн дотоод дүрэм журмаар олгогдсон бусад эрхүүд.

Холбооны төсвийн (төсвийн тэтгэмжээр) хөрөнгөөр эчнээгээр суралцаж буй оюутнуудад боловсролын салбарт төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтоосон журмын дагуу улсаас стипенди болон (буюу) улсын нийгмийн стипенди олгоно.

Холбооны төсвийн (төсвийн тэтгэмжээр) хөрөнгөөр эчнээгээр суралцаж буй аспирантуудад боловсролын салбарт төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтоосон журмын дагуу улсын стипенди олгоно.

Их сургууль нь өөрийн мэдэлд буй төсвийн хөрөнгө болон ашиг орлого бүхий үйл ажиллагаанаас олсон орлогынхоо хэмжээнд суралцагчдын нийгмийн халамжийн арга хэмжээнүүдийг бие даан боловсруулж, хэрэгжүүлэх бөгөөд үүний дотор тэдний материаллаг байдал, сурлагын амжилт болон Их сургуулийн олон нийтийн ажилд оролцсон байдлыг харгалзан стипенди, тэтгэмжийн хэмжээг тогтоож, мөн бусад төрлийн нийгмийн олговруудыг хэрэгжүүлнэ.



Unenbat
UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344, Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

6.3. Их сургуулийн суралцагчид нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Боловсролын хөтөлбөрийг шаргуу судалж, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг биелүүлж байх, үүний дотор сургалтын төлөвлөгөө болон ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд заасан хичээлүүдэд сууж байх, хичээлийн бэлтгэлийг бие даан хийж байх, сургалтын хөтөлбөрийн хүрээнд сурган хүмүүжүүлэх ажилтнуудын өгсөн даалгавруудыг гүйцэтгэж байх.
- Их сургуулийн Дүрэм, дотоод дүрэм, нийтийн байранд оршин суух дүрэм болон боловсролын үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Их сургуулийн бусад дүрэм журмын шаардлагуудыг биелүүлж байх.
- Өөрийн эрүүл мэндийг хамгаалж сайжруулах талаар санаа тавьж, ёс суртахууны, оюуны болоод бие бялдын хөгжил, өөрийгөө боловсруулахыг эрмэлздэг байх.
- Бусад суралцагчид болон ажилтнуудын нэр хүндийг эрхэмлэн хүндэтгэж, бусад суралцагчдын боловсрол олж авахад саад учруулахгүй байх.
- Их сургуулийн эд хөрөнгөд хайр гамтай хандах.
- Зардал бүрэн нөхөн төлөх нөхцөлтэйгөөр суралцаж байгаа тохиолдолд сургалтын төлбөрийг боловсролын тухай гэрээний дагуу цаг тухайд нь бүрэн төлж байх.
- Дотуур байранд амьдрахдаа төлбөрийг цаг тухайд нь гүйцэтгэх.
- Оросын Холбооны Улсын хууль тогтоомж, боловсролын тухай гэрээ (байгаа нөхцөлд), Их сургуулийн дотоод дүрэм журамд заасан бусад үүргүүд.

6.4. Их сургуулийн Дүрэм, дотоод журам, нийтийн байранд оршин суух дүрэм болон боловсролын үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Их сургуулийн бусад дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд суралцагчдад сахилгын шийтгэл оногдуулж байж болно – сануулах, донгодох, Их сургуулиас хасах.

Сахилгын дээр дурдсан зөрчлүүдийг удаа дараа гаргасан тохиолдолд 15 нас хүрсэн насанд хүрээгүй суралцагчийг Их сургуулийн шийдвэрээр сахилгын шийтгэл оногдуулах журмаар Их сургуулиас хөөх арга хэмжээ авч болно. Насанд хүрээгүй суралцагчийг сургуулиас хөөх шийтгэлийг, хэрэв сахилгын өөр арга хэмжээнүүд болон сурган хүмүүжүүлэхүйн нөлөө үзүүлэх арга хэмжээнүүд үр дүн өгөөгүй бөгөөд түүний цаашид Их сургуульд байх нь бусад суралцагчдад сөргөөр нөлөөлж, тэдгээрийн болон Их сургуулийн ажилтнуудын эрхийг зөрчин, мөн Их сургуулийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах болсон тохиолдолд хэрэглэнэ.

Суралцагчдыг өвчтэй, амралттай, жилийн чөлөөтэй, жирэмсний болон хүүхэд гаргасны амралттай буюу хүүхдээ асрах амралтаа эдэлж байх хугацаанд сахилгын шийтгэл оногдуулахыг хориглоно.

Их сургууль нь сахилгын шийтгэлийн хэлбэрийг сонгохдоо сахилгын зөрчлийн ноцтой байдал, гарах болсон шалтгаан болон нөхцөл байдал, суралцагчийн өмнөх сахилга батын байдал, түүний сэтгэлзүй-бие бялдын болон сэтгэл санааны байдал, мөн түүнчлэн суралцагчдын зөвлөл, эцэг эхийн зөвлөлийн саналуудыг харгалзана.



Y. Gan
UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

Суралцагчдад сахилгын шийтгэл оногдуулах болон суралцагчдын сахилгын шийтгэлийг болиулах журмыг боловсролын салбарт төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтооно.

6.5. Суралцагчийг доорх шалтгааны улмаас Их сургуулиас хассанаар боловсролын харилцаа дуусгавар болно:

1. Боловсрол эзэмшсэнтэй холбогдуулан (суралцаж дууссан)
2. Хугацаанаас өмнө бол дараах тохиолдлуудад:
 - Суралцагчийн буюу насанд хүрээгүй суралцагчийн эцэг эхийн (хууль ёсны төлөөлөгчид) санаачилгаар, үүний дотор мөн суралцагч нь боловсролын үйл ажиллагаа хэрэгжүүлэгч өөр байгууллагад боловсролын хөтөлбөрийг үргэлжлүүлэн эзэмших болсон тохиолдолд,
 - Их сургуулийн санаачилгаар:
 - o 15 нас хүрсэн суралцагчид Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу сахилгын арга хэмжээний журмаар хөөх шийтгэл оногдуулсан тохиолдолд.
 - o Мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн дагуу уг сургалтын хөтөлбөрийг шаргуу эзэмших болон сургалтын төлөвлөгөөг биелүүлэх үүргээ суралцагч биелүүлээгүй тохиолдолд.
 - o Суралцагчийн буруугаас Их сургуульд элсүүлэх журам зөрчигдөж, улмаар түүнийг Их сургуульд хууль бусаал элсүүлэхэд хүргэсэн болох нь тогтоодсон нөхцөлд.
 - o Суралцагчийн буюу насанд хүрээгүй суралцагчийн эцэг эхийн (хууль ёсны төлөөлөгчид) хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас, мөн Их сургууль татан буугдсан тохиолдолд.

Боловсролын харилцааг дуусгавар болгох бусад үндэслэлүүдээс гадна хуулийн этгээд болон (буюу) хувь хүний хөрөнгөөр суралцуулахаар сургуульд элсүүлэн авах үед суралцагчтай байгуулсан боловсролын гэрээг (цаашид Боловсролын төлбөртэй үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ гэх) үндэслэн, боловсролын төлбөртэй үйлчилгээ үзүүлэх тухай гэрээг төлбөртэй сургалтын үйлчилгээний төлбөрийн хугацаа хожимдуулсан тохиолдолд, мөн түүнчлэн боловсролын төлбөртэй үйлчилгээ үзүүлэх үүргийг зохих ёсоор биелүүлэх нь суралцагчийн үйлдлийн (эс үйлдлийн) улмаас боломжгүй болсон тохиолдолд энд заасан гэрээг хэрэгжүүлэх явдлаас Их сургууль дангаараа татгалзах замаар дангаар цуцлах эрхтэй байна.

Сургалтын төлбөрийн өрийг тогтоосон хугацаанд барагдуулаагүй мэргэжлийн боловсролын үндсэн хөтөлбөрүүдээр суралцагчдыг сургалтын хөтөлбөрийг шаргуу эзэмших болон сургалтын төлөвлөгөөг биелүүлэх үүргээ биелүүлээгүй гэж үзэн Их сургуулиас хасна.

Суралцагчийн буюу насанд хүрээгүй суралцагчийн эцэг эхийн (хууль ёсны төлөөлөгчид) санаачилгаар боловсролын харилцааг хугацаанаас өмнө дуусгавар болгох нь тухайн суралцагчийн хувьд Их сургуулийн өмнө ямарваа нэгэн нэмэлт үүрэг хариуцлага, үүний дотор эд материалын хариуцлага үүсэхэд хүргэхгүй.




UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

Боловсролын харилцааг дуусгавар болгох үндэслэл нь суралцагчийг Их сургуулиас хасах тухай Захирлын тушаал байна. Боловсролын тухай хууль тогтоомж болон Их сургуулийн дотоод журамд заасан суралцагчийн эрх үүргүүд түүний Их сургуулиас хасагдсан өдрөөр дуусгавар болно.

Боловсролын харилцаа хугацаанаас өмнө дуусгавар болох үед Их сургууль нь суралцагчид хууль тогтоомжийн дагуу суралцсан тухай магадлагаа олгоно.

- 6.6. Мэргэжлийн боловсролын үндсэн хөтөлбөрийг судалж дуусахаас өмнө өөрийн санаачилгаар Их сургуулиас хасагдсан этгээд нь хасагдсанаас хойш 5 жилийн дотор, гэхдээ тухайн этгээдийн хасагдсан хичээлийн жил (семестр) дуусахаас өмнө, сургуульд сул орон тоо байгаа бол сургалтын өмнөх нөхцөлүүдийг хэвээр үлдээн Их сургуульд суралцах эрхээ сэргээлгэх эрхтэй байна.

Өөрийн санаачилгаар Их сургуулиас хасагдсан Суралцагчийн Их сургуульд суралцах эрхийг сэргээх журам ба нөхцөлүүдийг Их сургуулийн дотоод журмын дагуу тогтооно.

- 6.7. Хэрэв тухайн этгээд холбооны төсвийн тусламжийн хөрөнгөөр анх удаа дээд боловсрол эзэмшиж байсан буюу эзэмшиж байгаа бол эрх сэргээх, шилжих болон шилжүүлэхэд Их сургуульд төлбөр авахгүй.

- 6.8. Их сургуульд сурган хүмүүжүүлэх (багшлах-профессорын бүрэлдэхүүн) ажилтнууд, эрдэм шинжилгээний ажилтнуудын албан тушаал, инженер техникийн, захиргаа аж ахуйн, үйлдвэрлэлийн болон бусад ажилтнуудын албан тушаалууд байх бөгөөд тэдгээр нь туслах үүргүүдийг гүйцэтгэнэ. Багшлах-профессорын бүрэлдэхүүний албан тушаалд декан, тэнхмийн эрхлэгч, профессор, доцент, ахлах багш, багш, туслахууд хамаарна.

- 6.9. Факультетын декан болон тэнхмийн эрхлэгчээс бусад бүх эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх ажилтнуудын албан тушаалыг орлон гүйцэтгэх явдлыг 5 (тав) хүртэл жилийн хугацаатай байгуулагдах хугацаат хөдөлмөрийн гэрээгээр хэрэгжүүлнэ. Эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх ажилтнуудын албан тушаалыг орлон гүйцэтгүүлэх тохиолдолд хугацаат хөдөлмөрийн гэрээ байгуулагдахаас өмнө тухайн албан тушаалыг орлон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтаар сонгох ажил явагдана. Заасан албан тушаалуудыг орлон гүйцэтгэх журмын тухай хууль дүрмийг боловсролын салбарт төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас батална.

Факультетын декан болон тэнхмийн эрхлэгчийн албан тушаалууд нь сонгуультай байна. Заасан албан тушаалуудын сонгууль явуулах журмыг энэхүү Дүрмийн 5.37 болон 5.38 зүйлд зааснаар тогтооно.

- 6.10. Их сургуулийн бүх шатны ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ цуцлах ажиллагааг Оросын Холбооны Улсын хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

- 6.11. Их сургуулийн бүх шатны ажилтнуудын эрх үүргийг Оросын Холбооны Улсын хууль тогтоомж, энэхүү Дүрэм, хөдөлмөрийн дотоод журам болон Их сургуулиас гаргасан бусад актууд, ажлын байрны тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээнүүдээр тогтооно.

Их сургуулийн ажилтнуудын эрх:

- Их сургуулийн эрдмийн зөвлөлүүдийн бүрэлдэхүүнд сонгох болон сонгогдох



Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

- Их сургуулийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэхэд оролцох
- Өөрийн мэргэжлийн үйл ажиллагааг зохион байгуулалт, материал техникийн хангамжаар хангуулах
- Хамтын гэрээ болон Их сургуулийн бусад дотоодын дүрэм журмын дагуу номын сан, мэдээллийн сан, сургалтын болон эрдэм шинжилгээний салбар нэгжүүдээр үнэгүй үйлчлүүлэх, мөн түүнчлэн Их сургуулийн нийгэм-ахуйн болон бүтцийн бусад салбар нэгжүүдийн үйлчилгээ авах.
- Их сургуулийн захиргааны гаргасан тушаал, шийдвэрийг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу давж заалдах.

Их сургуулийн ажилтнууд нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомж, Их сургуулийн Дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнүүд, ажлын байрны тодорхойлолт болон Их сургуулиас баталж гаргасан бусад актуудад заасан бусад эрхүүдийг эдэлнэ.

6.12. Их сургуулийн сурган хүмүүжүүлэх ажилтнууд энэхүү Дүрмийн 6.11-т заасан эрхүүдээс гадна дараах эрх, эрх чөлөөнүүдийг эдэлнэ:

- Багшлах эрх чөлөө, өөрийн санал бодлыг чөлөөтэй илэрхийлэх, мэргэжлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох явдлаас ангид байх эрх чөлөө.
- Сургалт болон хүмүүжилд сурган хүмүүжүүлэх ухааны үндэслэл бүхий хэлбэр, хэрэгсэл, арга барилыг чөлөөтэй сонгож хэрэглэх эрх.
- Бүтээлч санаачилга гаргах, сургалт болон хүмүүжилд хэрэгжүүлж буй боловсролын хөтөлбөр, аль нэг хичээл, курс, салбар ухааны (модуль) хүрээнд зохиогчийн хөтөлбөр болон арга барилыг боловсруулж хэрэглэх эрх чөлөө.
- Сурах бичиг, сургалтын гарын авлага, материал болон хэрэгслүүд, сургалт хүмүүжлийн бусад арга хэрэгслүүдийг боловсролын хөтөлбөрийн дагуу боловсролын тухай хуулинд заасан журамд нийцүүлэн сонгох эрх.
- Боловсролын хөтөлбөр боловсруулах, үүний дотор сургалтын төлөвлөгөө, календарчилсан сургалтын график, сургалтын ажлын эд зүйлс, курс, салбар ухаан (модуль), аргазүйн материал болон боловсролын хөтөлбөрийн бусад бүрдэл хэсгүүдийг боловсруулахад оролцох.
- Эрдэм шинжилгээний, шинжлэх ухаан-техникийн, уран бүтээлийн, судалгааны ажил хэрэгжүүлэх, туршилтын болон олон улсын үйл ажиллагаа, инновац боловсруулах болон нэвтрүүлэхэд оролцох.
- Номын сангууд болон мэдээллийн нөөцүүдийг үнэ төлбөргүй ашиглах эрх, мөн Их сургуулийн дотоод хууль дүрмээр тогтоосон журмын дагуу мэдээл-харилцаа холбооны сүлжээ болон өгөгдлийн сангууд, сургалтын болон аргазүйн материалууд, музейн сан хөмрөг, Их сургуулийн материал техникийн хангамжийн хэрэгслүүд, Их сургуульд явагдаж буй шинжлэх ухааны буюу эрдэм шинжилгээний үйл ажиллагаанд нэвтрэх.
- Их сургуулийн боловсролын, аргазүйн болон эрдэм шинжилгээний үйлчилгээнүүдийг Оросын Холбооны Улсын хууль тогтоомж буюу Их сургуулийн дотоод дүрэм журмын дагуу үнэ төлбөргүй авах эрх.



UNENSAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@sovon.mn

- Их сургуулийн удирдлага, үүний дотор хамтын удирдлагын байгууллагуудад Их сургуулийн дүрмээр тогтоосон журмын дагуу оролцох эрх.
 - Их сургуулийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлуудыг авч хэлэлцэхэд захиргааны болон олон нийтийн байгууллагуудар дамжуулан оролцох эрх.
 - Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор тогтоосон хэлбэр, журмын дагуу мэргэжлийн олон нийтийн байгууллагуудад нэгдэх эрх.
 - Боловсролын харилцаанд оролцогч талуудын маргааныг зохицуулах комисст хандах эрх.
 - Мэргэжлийн нэр хүндээ хамгаалуулах, сурган хүмүүжүүлэх ажилтнуудын ёсзүйн хэм хэмжээний зөрчлийг шударга бөгөөд үнэн зөвөөр хянан шийдвэрлүүлэх эрх.
- 6.13. Энэхүү Дүрмийн 6.12-т заасан эрх, эрх чөлөөнүүд нь Их сургуулийн дотоод дүрэм журмаар бататгаж өгсөн боловсролын харилцааны бусад оролцогчдын эрх, эрх чөлөө, Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн шаардлагууд, сурган хүмүүжүүлэх ажилтнуудын ёсзүйн хэм хэмжээг сахин биелүүлэх замаар хэрэгжих ёстой.
- 6.14. Сурган хүмүүжүүлэх ажилтнууд нь дараах хөдөлмөрийн эрх болон нийгмийн баталгаануудыг эдэлнэ:
- Ажлын богиносгосон цагаар ажиллах эрх.
 - Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааныхаа чиглэлээр гурван жилд нэгээс доошгүй удаа мэргэжлийн нэмэлт боловсрол эзэмших эрх.
 - Оросын Холбооны Улсын Засгийн газраас үргэлжлэх хугацааг нь тогтоодог жил бүрийн цалинтай уртасгасан үндсэн амралтын эрх.
 - Сурган хүмүүжүүлэх ажлыг тасралтгүй 10-аас доошгүй жил ажилласан бол боловсролын салбарт төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтоосон журмын дагуу нэг жил хүртэл хугацаатай урт хугацааны амралт эдлэх эрх.
 - Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу өндөр насны даатгалын тэтгэврийг хугацаанаас өмнө тогтоолгох эрх.
 - Орон байрны хэрэгцээтэй байгаа хүмүүсийн жагсаалтад бүртгэлтэй сурган хүмүүжүүлэх ажилтнуудад дараалал харгалзахгүйгээр нийгмийн түрээсийн гэрээгээр байр олгох эрх, орон сууцны тусгай сангаас орон байр олгох эрх.
 - Оросын Холбооны Улсын орон сууцны тухай хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу орон сууцны тусгай сангаас орон байр олгох эрх.
 - Холбооны хуулиуд болон Оросын Холбооны Улсын субъектуудын хууль эрхзүйн актуудаар тогтоосон хөдөлмөрийн бусад эрх, нийгмийн тусламжийн арга хэмжээнүүд.
- 6.15. Их сургуулийн эрдэм шинжилгээний ажилтнууд нь энэхүү Дүрмийн 6.12 болон шинжлэх ухаан болон төрөөс явуулах шинжлэх ухаан техникийн бодлогын тухай хууль тогтоомжид заасан эрхүүдээс гадна дараах эрхүүдийг эдэлнэ:



Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

- Их сургуулийн хамтын удирдлагын байгууллагуудын бүрэлдэхүүнд Их сургуулиас тогтоосон журмын дагуу орох,
- Аюулгүй байдлын шаардлагад нийцсэн, шинжлэх ухааны судалгааны онцлогт хамгийн ихээр тохирсон бөгөөд тэдгээрийн өндөр чанарыг хангасан шинжлэх ухааны судалгааны арга, хэрэгслүүдийг сонгох.
- Их сургуулийн боловсрол, аргазүйн болон эрдэм шинжилгээний үйлчилгээнүүдийг Оросын Холбооны Улсын хууль тогтоомж буюу Их сургуулийн дотоод дүрэм журмын дагуу үнэ төлбөргүй авах.

6.16. Их сургуулийн ажилтнуудын үүрэг:

- Оросын Холбооны Улсын хөдөлмөрийн болон бусад хууль тогтоомж, энэхүү Дүрмийг дагаж мөрдөх.
- Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн ажил үүргээ шударгаар биелүүлж, хөдөлмөрийн дотоод журам болон Их сургуулийн бусад дотоод дүрэм журмыг сахиж, Их сургуулийн удирдах байгууллагын шийдвэрүүд, хөдөлмөр хамгаалал болон техникийн аюулгүй байдлын шаардлагуудыг биелүүлж байх.
- Их сургуулийн нутаг дэвсгэр дээр (хичээлийн танхим, лабораториуд, тэнхимүүд болон бусад газарт) дэг журам болон сахилга батыг хангаж, Их сургуулийн эд хөрөнгөд хайр гамтай хандаж байх.
- Өөрсдийн ажил үүргийг биелүүлж чадахгүй болсон тухай болон шалтгааны талаар цаг тухайд нь захиргаанд мэдэгдэж байх.
- Ажил үүрэг гүйцэтгэхтэй холбоотойгоор олж мэдсэн Их сургуулийн ажилтнууд болон суралцагчдын хувийн мэдээллийг бусдад тараахгүй байх.

Их сургуулийн ажилтнууд нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомж, Их сургуулийн Дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнүүд, ажлын байрны тодорхойлолт болон Их сургуулиас баталж гаргасан бусад актуудад заасан бусад үүргүүдийг биелүүлнэ.

6.17. Их сургуулийн сурган хүмүүжүүлэх ажилтнууд нь энэхүү Дүрмийн 6.16-д заасан үүргүүдээс гадна дараах үүргүүдийг хүлээнэ:

- Өөрийн үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд явуулж, зааж буй хичээл, курс, салбар ухааны (модуль) батлагдсан ажлын хөтөлбөрийн дагуу бүрэн хэмжээгээр хэрэгжих явдлыг хангах.
- Эрхзүй, ёс суртахууны болон ёсзүйн хэм хэмжээнүүдийг сахин, мэргэжлийн ёсзүйн шаардлагуудыг биелүүлэх.
- Суралцагчид болон боловсролын харилцааны бусад оролцогчдын нэр төрийг хүндлэх.
- Суралцагчдын танин мэдэх идэвх, бие даасан байдал, санаачилга, бүтээлч авьяас чадварыг хөгжүүлэн, иргэний байр суурь, орчин үеийн нөхцөлд ажиллаж, амьдрах чадварыг бий болгож, суралцагчдад эрүүл аюулгүй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх.
- Сурган хүмүүжүүлэх ухааны үндэслэлтэй бөгөөд боловсролын өндөр чанарыг хангасан сургалт хүмүүжлийн арга, хэрэгслүүдийг ашигладаг байх.




UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@sovon.mn

- Суралцагчдын сэтгэл зүй бие бялдрын хөгжлийн онцлог болон эрүүл мэндийн байдлыг харгалзан, эрүүл мэндийн хувьд хязгаарлагдмал боломж бүхий хүмүүс боловсрол олж авахад шаардагдах тусгай нөхцөлүүдийг хангаж, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн байгууллагуудтай хамтран ажиллах.
- Өөрийн мэргэжлийн ур чадварыг тогтмол дээшлүүлж байх.
- Боловсролын тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу ажиллаж буй албан тушаалд тохирч байгаа эсэхийг тогтоох аттестатчилалд орох.
- Хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу урьдчилсан эрүүл мэндийн үзлэгт ажилд орохдоо, тогтмол болон ээлжит бус эрүүл мэндийн үзлэгт Их сургуулийн томилолтоор орж байх.
- Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу хөдөлмөр хамгааллын талаарх сургалт болон мэдлэг, чадвар шалгах шалгалтад орж байх.

Сурган хүмүүжүүлэх ажилтнууд нь хэрэв энэ нь сурган хүмүүжүүлэх ажилтнуудын хооронд ашиг сонирхлын зөрчилд хүргэхээр байвал Академид суралцагчдад боловсролын төлбөртэй үйлчилгээ үзүүлэх эрхгүй байна.

Сурган хүмүүжүүлэх ажилтнуудад боловсролын үйл ажиллагааг улстөрийн ухуулга, суралцагчдыг улстөрийн, шашны болон бусад үзэл бодлыг хүлээн албадан зөвшөөрүүлэх буюу тэдгээрээс татгалзуулахын тулд, нийгмийн, арьсны өнгө, үндэсний болон шашны хагарал үүсгэх, иргэдийн нийгмийн гарал, арьсны өнгө, яс үндэс, шашны болон хэлний ялгаа, тэдгээрийн шашинд хандах хандлагаар нь, үүний дотор суралцагчдад улс түмнүүдийн түүхийн, үндэсний, шашны болон соёлын уламжлалын тухай нотлогдоогүй мэдээ мэдээлэл хүргэх замаар онцгой, бүгдээс илүү, эсвэл дутуу дулимаг болохыг ухуулсан сургал нэвтрүүлэг хийх, мөн түүнчлэн суралцагчдыг Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн эсрэг үйлдэлд турхирахад ашиглахыг хориглоно.

6.18. Их сургуулийн эрдэм шинжилгээний ажилтнууд нь энэхүү Дүрмийн 6.16 болон шинжлэх ухаан болон төрөөс явжглах шинжлэх ухаан техникийн бодлогын тухай хуулинд заасан үүргүүдээс гадна дараах үүргүүдийг хүлээнэ:

- Сонгосон мэргэжил, мэргэшил буюу бэлтгэх чиглэлээр суралцагчдын мэргэжлийн ур чадварыг бий болгох.
- Суралцагчдын бие даасан, санаачилгатай байдал, бүтээлч авьяас чадварыг хөгжүүлэх.

6.19. Их сургуулийн сурган хүмүүжүүлэх ажилтнуудын ажлын цагийн болон амралтын цагийн горимыг хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журам, Их сургуулиас гаргасан дотоодын бусад актууд, хөдөлмөрийн гэрээ, ажлын график болон хичээлийн хуваариар боловсролын салбарт төрийн бодлого боловсруулах болон хууль-эрхзүйн зохицуулалт хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтоосон онцлогуудыг харгалзан хөдөлмөрийн хууль тогтоомжийн шаардлагуудад нийцүүлэн тогтооно.

Сурган хүмүүжүүлэх ажилтнуудын ажлын цагийг богиносгосон цагаар буюу 7 хоногт 36-гаас илүүгүй цагаар тогтооно.

Сурган хүмүүжүүлэх ажилтнуудын хичээлийн ачааллыг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу тэнхмийн мэргэжлийн ур чадвар болон чиглэлээс



Unenbat
UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

хамааруулан Их сургуулиас бие даан тогтоох бөгөөд мөрдөгдөж буй хууль тогтоомжид заасан тохиолдлуудад дээд хязгаараар хаязгаарлагдаж байж болно.

- 6.20. Сургалт, арга зүй, эрдэм шинжилгээ, хүмүүжлийн ажил болон дүрмийн бусад үйл ажиллагаанд гаргасан амжилтын төлөө сурган хүмүүжүүлэх ажилтнуудад болон сурлагын амжилт ба эрдэм шинжилгээ, соёл олон түмний болон эрүүл мэнд-спортын ажилд идэвхтэй оролцсоны төлөө суралцагсдад Их сургуулиас янз бүрийн хэлбэрээр сэтгэл санааны болон эд материалын урамшууллуудыг Их сургуулийн Эрдмийн зөвлөлөөс гаргаж улмаар Их сургуулийн Захирлын баталсан журмын дагуу тогтоож олгоно.
- 6.21. Их сургуулийн хөдөлмөрийн хөлсний систем, мөн түүнчлэн ажилтнуудын сэтгэл санааны болон эд материалын урамшууллын хэлбэрийг цалин хөлсний тухай журам болон Их сургуулиас гаргасан дотоодын бусад актуудаар тогтооно.

7. ДЭЭД МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙ БЭЛТГЭЛ

- 7.1. Их сургууль нь дээд мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх үйл ажиллагааг аспирантурт эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх ажилтан бэлтгэх хөтөлбөрүүдээр дамжин хэрэгжүүлнэ.
- 7.2. Аспирантурт элсүүлэн суралцуулах ажлыг төрийн эрх бүхий байгууллагаас баталсан элсэлтийн хяналтын тооны дагуу уралдаант шалгаруулалтын үндсэн дээр болон гэрээний (төлбөртэй) үндсэн дээр (элсэлтийн хяналтын тооноос гадуур) хэрэгжүүлнэ. Аспирантурын сургалт өдрөөр болон эчнээгээр гэсэн 2 хэлбэрээр явагдана.
- 7.3. Аспирантурт суралцагч элсүүлэх ажлыг боловсролын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу аспирантурт эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх ажилтан бэлтгэх боловсролын хөтөлбөрүүдээр явагдана.
- 7.4. Гадаадын иргэдийг аспирантур, докторантурт элсүүлэх болон зэрэг горилогчоор их сургуультай холбох үйл ажиллагааг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу Оросын Холбооны Улсын олон улсын гэрээ болон засгийн газар хоорондын гэрээний үндсэн дээр, мөн түүнчлэн хуулийн этгээд болон (буюу) хувь хүнтэй Их сургуулийн байгуулсан сургалтын төлбөр төлөх тухай заалт бүхий боловсролын гэрээг үндэслэн хэрэгжүүлнэ.
- 7.5. Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэрт байнга оршин сууж буй харьяалалгүй хүмүүсийг аспирантурт элсүүлэх ажлыг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.
- 7.6. Аспирантуудын эрх, үүрэг, нийгмийн баталгаа болон хөнгөлөлтүүдийг Оросын Холбооны Улсын хууль тогтоомж, Дүрэм болон Их сургуулийн дотоодын бусад актуудаар тогтооно.
- 7.7. Аспирантурт эрдэм шинжилгээ-сурган хүмүүжүүлэх ажилтан бэлтгэх хөтөлбөрүүдийг судалж улмаар Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу зохих мэргэшлээр дэд эрдэмтний эрдмийн зэрэг горилсон эрдэм шинжилгээний ажил (диссертац) бичиж хамгаалсан хүмүүст дэд эрдэмтний эрдмийн зэрэг хүртээж, дэд эрдэмтний диплом олгоно.



UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

Төгсөлтийн улсын аттестатчиллыг амжилттай давсан хүмүүст аспирантурын хөтөлбөрөөр дээд боловсрол олж авсан болохыг гэрчлэх аспирантур төгссөн тухай диплом олгоно.

- 7.8. Аспирантурын хөтөлбөр эзэмшилтийн чанарын хяналтад сурлагын урсгал шалгалт, сурацагчдын завсрын аттестатчиллал болон аспирантуудын төгсөлтийн (улсын шалгалт) аттестатчилал багтана.

8. ИХ СУРГУУЛИЙН ЭДИЙН ЗАСАГ

- 8.1. Их сургууль нь бие даан санхүү-аж ахуйн үйл ажиллагаа явуулж, гэрээ байгуулах, өөрийн үүрэг болон Оросын Холбооны Улсын хууль тогтоомж болон энэхүү Дүрэмд харшлахгүй бусад нөхцөлүүдийг тодорхойлохтой холбогдсон асуудлуудыг шийдвэрлэнэ.

Их сургууль нь өөрийн үүргүүдийн биелэлтийг санхүү-аж ахуйн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хангаж байдаг болно.

- 8.2. Дүрэмд заасан үйл ажиллагаануудын хэрэгжилтийг хангах үүднээс Их сургуулийн эд хөрөнгийг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу шуурхай удирдлагын эрхтэйгээр түүний мэдэлд хариуцуулсан байна. Их сургуулийн эд хөрөнгийн өмчлөгч нь Оросын Холбооны Улс байна.

Их сургуулийн зүгээс өөрийн дүрмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эзэмшил газруудыг түүний мэдэлд байнгын (хугацаагүй) ашиглалтын эрхтэйгээр олгосон байдаг болно.

Иргэний эргэлтэд хэрэглэхийг хязгаарласан буюу иргэний эргэлтээс гаргасан Оросын Холбооны Улсын улс түмнүүдийн соёлын өвийн объектууд (түүх соёлын дурсгалууд), соёлын үнэт зүйлс, байгалийн нөөц (эзэмшил газраас бусад) нь холбооны хууль болон Оросын Холбооны Улсын бусад хууль эрхзүйн актуудаар тогтоосон нөхцөлүүд болон журмын дагуу Их сургуулийн нэр дээр бүртгэгдэнэ.

- 8.3. Өмчлөгчийн зүгээс шуурхай удирдлагын эрхтэйгээр нэр дээр нь бүртгүүлсэн эд хөрөнгийг Их сургууль өөрийн үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн уг эд хөрөнгийн зориулалтын дагуу хуулиар тогтоосон хүрээнд ашиглах бөгөөд, хэрэв хуулинд өөрөөр заагаагүй бол, уг эд хөрөнгийг түүний өмчлөгчийн зөвшөөрлөөр захиран зарцуулна.

- 8.4. Их сургууль нь өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр түүний нэр дээр өмчлөгчийн бүртгүүлсэн буюу өмчлөгчөөс уг эд хөрөнгийг худалдан авахад зориулж олгосон өмчлөгчийн мөнгөн хөрөнгөөр худалдан авсан онцгой үнэ бүхий хөдлөх хөрөнгө, мөн түүнчлэн үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулах эрхгүй.

Онцгой үнэ бүхий хөдлөх хөрөнгө гэдэгт түүнгүйгээр Их сургууль өөрийн дүрмийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явдал ихээхэн хүндрэх тийм хөдлөх эд хөрөнгийг ойлгоно. Эд хөрөнгийг онцгой үнэ бүхий хөдлөх хөрөнгийн ангилалд хамааруулах журмыг Оросын Холбооны Улсын Засгийн газар тогтооно.

Онцгой үнэ бүхий хөдлөх хөрөнгийн төрөл ба жагсаалтыг ОХУ-ын ХААЯ-ны гаргасан журмын дагуу тодорхойлно.



UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

Шуурхай удирдлагын эрхтэйгээр түүний мэдэлд буй бусад эд хөрөнгийг, хэрэв Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол, Их сургууль бие даан захиран зарцуулах эрхтэй байна.

8.5. Их сургуулийн санхүүгийн хангамж дараах байдлаар хангагдана:

- Төрийн үйлчилгээ үзүүлэх (ажил гүйцэтгэх) улсын даалгаврын биелэлтийг санхүүжүүлэхэд зориулж холбооны төсвөөс олгох тусламж тэтгэлэг.
- Үүсгэн байгуулагч бусад зорилгод зориулж тусламж тэтгэлэг олгох тухай шийдвэр гаргасан мөчөөс эхлэн бусад зорилгод зориулсан тусламж.
- Төсвийн хөрөнгө оруулалтын тухай Үүсгэн байгуулагчийн шийдвэр гарсан даруйд төсвийн хөрөнгө оруулалт.
- Хувь хүмүүсийн өмнө хүлээсэн олон нийтийн үүргийн биелэлтэд зориулсан төсвийн тусламж тэтгэлэг.
- Орлого бүхий үйл ажиллагаанаас, үүний дотор энэхүү Дүрмийн 1.8-д заасны дагуу боловсролын төлбөртэй үйл ажиллагаанаас олсон хөрөнгө.
- Хуулийн этгээдүүд болон хувь хүмүүсийн, үүний дотор гадаадын иргэд болон гадаадын хуулийн этгээдүүдийн сайн дурын хандив болон зорилтот хураамж.
- Их сургуулийн Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу олгосон тэтгэлгийн (төсөл) тусламжтайгаар олж авсан хөрөнгө.
- Дүрмийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд зориулж хувь хүмүүс болон хуулийн этгээдүүдээс үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, үүний дотор мөн гэрээ хэлцлийн дагуу бүс нутгийн болон орон нутгийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх ажлын хүрээнд Оросын Холбооны Улсын субъектуудын төсвийн хөрөнгө болон (буюу) орон нутгийн төсвийн хөрөнгө.
- Түрээсийн төлбөр, харилцагч, давхар харилцагчдаас олсон болон ашиглалтын, нийтийн аж ахуйн болон захиргаа-аж ахуйн үйлчилгээний нөхөн төлбөрт авсан хөрөнгө.
- Гэрээний нөхцөл зөрчсөний төлөө нөгөө талын шилжүүлсэн хөрөнгө.
- Их сургуулийн оюутны дотуур байранд оршин суугчдын төлбөр.
- Даатгалын тохиолдол үүсэх үед автомашин эзэмшигчдээс жолоочийн иргэний хариуцлагын албан журмын даатгалын гэрээгээр, мөн түүнчлэн бусад төрлийн даатгалын гэрээгээр Их сургуулийн хүлээн авсан мөнгөн хөрөнгө.
- Худалдан авалтын үйл ажиллагаанд оролцогчдоос Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу худалдан авалтын бичиг баримт гаргаж өгсний төлбөр.
- Үүсгэн байгуулагч (оролцогч) нь Их сургууль болох аж ахуйн нэгдлүүдийн дүрмийн санд эзэмшиж буй хувийн (хувьцаа) захиран зарцуулалтаас олсон орлого, мөн түүнчлэн эдгээр аж ахуйн нэгдлүүдийн үйл ажиллагаанаас олсон ашгийн зарим хэсэг хэлбэрээр олсон орлого, жижиг дунд үйлдвэрүүд болон Их сургуулийн аж ахуйн тооцоо бүхий салбар нэгжүүдийн үйл ажиллагаанаас олсон орлого.
- Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэрүүд.




UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- 8.6. Их сургууль нь санхүү-аж ахуйн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу өөрийн хөрөнгө мөнгийг зарцуулах чиглэл болон журмыг бие даан тодорхойлж, мөн, хэрэв хөрөнгө мөнгө олгох нөхцөлүүдэд өөрөөр заагаагүй бол, их сургуулийн ажилтнуудын цалин хөлс, урамшуулалд зарцуулах хэсгийн эзлэх хувь хэмжээг тогтооно.
- 8.7. Их сургууль нь зээлийн байгууллагад мөнгөн хөрөнгө байршуулах, мөн түүнчлэн үнэт цаасны арилжаа явуулах эрхгүй байна.
- 8.8. Их сургууль нь төрийн өмчийн удирдлага хариуцсан холбооны агентлаг буюу цаашид "Росимущество" хэмээх байгууллагад (түүний орон нутгийн салбар) холбооны өмч хөрөнгө болон Их сургуулийн тухай мэдээлэл бүхий баримт бичгүүдийг (тэдгээрийн хуулбарууд) гарган өгч, мөн түүнчлэн Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу Их сургуулийн холбооны өмч хөрөнгийг бүртгэх ажлыг хэрэгжүүлнэ.
- 8.9. Их сургууль нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу эд хөрөнгийн түрээслэгч болон (буюу) эд хөрөнгө түрээслүүлэгч байх эрхтэй болно.
- ОХУ-ын ХААЯ-ны зөвшөөрлөөр зохих журмын дагуу их сургуулийн нэр дээр бүртгэгдсэн буюу уг эд хөрөнгийг худалдан авахад зориулж ОХУ-ын ХААЯ-наас олгосон хөрөнгө мөнгөөр худалдан авсан үл хөдлөх хөрөнгө ба онцгой үнэ бүхий хөдлөх хөрөнгийг түрээслүүлэх тохиолдолд уг эд хөрөнгийн арчлалтын санхүүжилтийг ОХУ-ын ХААЯ хариуцахгүй болно.
- 8.10. Их сургууль нь өөрийн эзэмшиж буй оюуны үйл ажиллагааны үр дүнгийн онцгой эрхүүдийг, үүний дотор зохих үр дүнгүүдийг гэрээгээр тогтоосон хэмжээ хязгаарын хүрээнд (тусгай зөвшөөрлийн гэрээ) ашиглах эрхийг бусдад олгох замаар захиран зарцуулах эрхтэй байна.
- 8.11. Их сургууль нь өмчлөгчийн зөвшөөрлөөр арилжааны бус байгууллагуудад мөнгөн хөрөнгө (хэрэв тэдгээрийг олгох нөхцөлүүдэд өөрөөр заагаагүй бол) болон их сургуулийн нэр дээр өмчлөгчийн бүртгүүлсэн буюу уг эд хөрөнгийг худалдан авахад зориулж өмчлөгчийн олгосон хөрөнгө мөнгөөр Их сургуулийн худалдан авсан онцгой үнэ бүхий хөдлөх хөрөнгө, мөн түүнчлэн үл хөдлөх хөрөнгөөс бусад эд хөрөнгийг тэдгээрийн үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигчийн журмаар олгох эрхтэй байна.
- 8.12. Их сургууль нь энэхүү Дүрмийн 1.9 дэх заалтын дагуу үүсгэн байгуулагдах аж ахуйн нэгдлүүдийн дүрмийн сан болон аж ахуйн нөхөрлөлүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд хувь оруулах журмаар онцгой эрхүүдийг нь Их сургууль (мөн бусад этгээдүүдтэй хамтран) эзэмшдэг оюуны үйл ажиллагааны үр дүнгүүдийг (цахим тооцоолон бодох машины програм, өгөгдлийн сан, нээлт, ашигтай загвар, аж үйлдвэрийн загвар, селекцийн ололтууд, интеграль бичил схемын топологиуд, үйлдвэрлэлийн нууц (ноу хау)) ашиглах эрхийг олгоно.
- 8.13. Их сургууль нь энэхүү Дүрмийн 8.11-т заасан эд хөрөнгийг нэр дурдсан аж ахуйн нэгдлүүд болон аж ахуйн нөхөрлөлүүдийн дүрмийн (хувь нийлүүлсэн) санд нийлүүлэх буюу тэдгээрийн үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигчийн журмаар тэдэнд уг хөрөнгийг Оросын Холбооны Улсын иргэний хуулиар тогтоосон журмын дагуу өөр бусад байдлаар шилжүүлэх эрхтэй байна.
- 8.14. Үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигч нь Их сургууль болох аж ахуйн нэгдлүүдийн дүрмийн сан дахь хувь эзэмшил буюу хувьцаа, мөн аж ахуйн нөхөрлөлүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан хандив зэргийг захиран




UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

зарцуулснаас олсон орлого нь түүний бие даан захиран зарцуулах мэдэлд шилжинэ.

8.15. Их сургууль нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан тохиолдлуудад түүнд заасан журмын дагуу эд хөрөнгөтэй холбоотой арилжаа хийх эрхтэй байна.

8.16. Их сургууль нь ОХУ-ын ХААЯ-наас урьдчилан зөвшөөрөл авснаар Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасны дагуу том дүнтэй арилжаа хийж болно.

Их сургууль нь, хэрэв Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол, болзошгүй үр дагавар нь Их сургуулийн нэр дээр бүртгэлтэй эд хөрөнгө, эсвэл холбооны төсвөөс буюу Оросын Холбооны Улсын төрийн төсвийн бус сангийн хөрөнгөнөөс Их сургуульд олгосон хөрөнгөөр худалдан авсан эд хөрөнгө хураагдах буюу барьцаалагдах явдал байх магадлалтай арилжааг хийх эрхгүй болно.

Энэхүү зүйлийн заалтыг зөрчиж хийсэн арилжааны үр дүнд, уг арилжааг хүүчингүйд тооцсон эсэхээс үл хамааран, Их сургуульд учруулсан хохирлын хэмжээгээр Их сургуулийн өмнө Их сургуулийн Захирал хариуцлага хүлээнэ.

8.17. Их сургууль нь эд хөрөнгийн өмчлөгчийн өмнө өөрийн мэдэлд байгаа өмч хөрөнгө, үүний дотор мөн Их сургуулийн ашиг орлого бүхий үйл ажиллагаанаас олсон орлогоор худалдан авсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал болон үр дүнтэй ашиглалтыг хариуцна.

8.18. Их сургууль нь Их сургуулийн хэрэгцээнд зориулж бараа, ажил үйлчилгээ худалдан авах болон хэлцэл болон буюу иргэний эрхзүйн гэрээ байгуулах үйл ажиллагааг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

8.19. Их сургууль нь өөрийн үүргүүдийн дагуу хариуцлагыг шуурхай удирдлагын эрхтэйгээр өөрийн мэдэлд байгаа нийт хөрөнгийн хэмжээгээр, үүнд түүний нэр дээр өмчлөгчийн бүртгүүлсэн буюу өмчлөгчөөс уг эд хөрөнгийг худалдан авахад зориулж олгосон өмчлөгчийн мөнгөн хөрөнгөөр худалдан авсан онцгой үнэ бүхий хөдлөх хөрөнгө, мөн түүнчлэн үл хөдлөх хөрөнгөөс бусад ашиг орлого бүхий үйл ажиллагаанаас олсон орлогоор худалдан авсан эд хөрөнгөөр, уг эд хөрөнгө Их сургуулийн шуурхай удирдлагад ямар үндэслэлээр шилжин ирсэн болон ямар хөрөнгөөр түүнийг худалдан авснаас үл хамааран, хариуцлага хүлээнэ.


Их сургуулийн иргэдэд хохирол учруулсантай холбогдсон үүргийн хувьд Оросын Холбооны Улсын Иргэний хуулийн дагуу албадан гаргуулах өмчийн хэмжээ хүрэлцэхгүй байх тохиолдолд хамтарсан давхар хариуцлагыг Их сургуулийн хөрөнгийн өмчлөгч хүлээнэ.

8.20. Их сургууль нь өөрийн эд хөрөнгийн өмчлөгчийн үүргүүдийн төлөө хариуцлага хүлээхгүй.

8.21. Их сургуулийн үйлчилгээ болон бүтээгдэхүүний үнийг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу тогтооно.

8.22. Их сургууль нь ажилтнуудынхаа цалин хөлсний санг Их сургуулийн үйл ажиллагаанд зарцуулагдах холбооны төсвийн хөрөнгө болон (буюу) Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор хориглоогүй өөр бусад эх үүсвэрүүдээс бие даан бүрдүүлнэ.




UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

Их сургууль нь өөрийн мэдэлд буй цалин хөлсөнд зориулагдсан хөрөнгийн хэмжээнд нэмэлт цалин, нэмэгдэл, шагнал болон бусад урамшууллын хэмжээ, мөн түүнчлэн удирдагчаас бусад бүх шатны ажилтнуудын албан тушаалын цалингийн хэмжээг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу бие даан тогтооно.

9. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ БА ХЯНАЛТ

9.1. Их сургууль нь нягтлан бодох бүртгэл хөтөлж улмаар нягтлан бодох бүртгэлийн, санхүүгийн болон статистикийн тайлан, бусад төрлийн тайлангуудыг Оросын улсын Сангийн Яамнаас тогтоосон журмын дагуу гаргаж өгч, мөн түүнчлэн татварын бүртгэл хөтөлж харьяаллын дагуу татварын албанд бүхий л шаардлагатай баримтуудыг гаргаж өгч байна.

Нягтлан бодох бүртгэлийн болон татварын бүртгэлийг хөтлөх хэлбэр болон журмыг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу тогтооно. Нягтлан бодох бүртгэлийн улирлын болон жилийн эцсийн тайлангуудыг гаргаж өгөх хугацааг ОХУ-ын ХААЯ тогтооно. Их сургууль нь ОХУ-ын ХААЯ-ны өмнө ажлаа тайлагнах бөгөөд төсвийн болон Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор тогтоосон бусад тайлангуудыг гаргаж байна.

9.2. Их сургуулийн салбарууд болон Их сургуулийн бүтцийн бусад тусдаа нэгжүүд нь Их сургуулиас тогтоосон хугацаанд нягтлан бодох бүртгэлийн, санхүүгийн, статистикийн болон Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор тогтоосон бусад тайлангуудыг Их сургуульд гаргаж өгнө.

9.3. Санхүү-аж ахуйн сахилга бат болон Их сургуулийн шуурхай удирдлагын мэдэлд байгаа эд хөрөнгийн ашиглалтын үр нөлөөнд тавих хяналтыг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу ОХУ-ын ХААЯ болон бусад эрх бүхий төрийн байгууллагууд хэрэгжүүлнэ.

9.4. Их сургуулийн үйл ажиллагаа энэхүү Дүрэмд заасан зорилгод нийцэж байгаа эсэхэд ОХУ-ын ХААЯ болон бусад эрх бүхий төрийн байгууллагууд хяналт тавина.

9.5. Улсын тайланг гажуудуулсны төлөө Их сургуулийн албан тушаалтнуудад Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор тогтоосон сахилгын, эд материалын, захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

10. ИХ СУРГУУЛИЙН ОЛОН УЛСЫН БОЛОН ГАДААД ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

10.1. Их сургууль нь дээд боловсролын бакалавр, мэргэшил, магистр, дээд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, мэргэжлийн нэмэлт боловсрол олгох, эрдэм шинжилгээний болон (буюу) шинжлэх ухаан техникийн, багшлах болон бусад үйл ажиллагааны хүрээнд Оросын Холбооны Улсын хууль тогтоомж болон Оросын Холбооны Улсын олон улсын гэрээнүүдийн дагуу олон улсын хамтын ажиллагаа хэрэгжүүлэх эрхтэй.

10.2. Их сургуулийн олон улсын үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд нь:



UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Их сургуулийн суралцагчид, сурган хүмүүжүүлэх болон эрдэм шинжилгээний ажилтнуудыг гадаадад суралцахад зориулсан тусгай стипенди олгодог гадаад улс орны боловсролын байгууллагуудад томилон явуулах, мөн түүнчлэн Их сургуульд гадаадын суралцагчид, сурган хүмүүжүүлэх болон эрдэм шинжилгээний ажилтнуудыг суралцуулах, мэргэжил дээшлүүлэх болон эрдэм шинжилгээний болон боловсролын үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор элсүүлэх, мөн солилцооны хөтөлбөрүүдийн хүрээнд хүлээн авах.
- Олон улсын байгууллагуудын үйл ажиллагаа болон олон улсын боловсролын, эрдэм шинжилгээний болон шинжлэх ухаан техникийн төслүүд, чуулган, хуралдаан, бага хурал, семинарууд зохион байгуулж явуулахад оролцох буюу дээрх арга хэмжээнүүдийг бие даан явуулах, мөн түүнчлэн Их сургуулийн үйл ажиллагааны чиглэлээр хоёр талын болон олон талт хамтын ажиллагаанд үндэслэн сургалт-эрдэм шинжилгээний ном, товхимол солилцох.
- Боловсролын салбарт хамтарсан судалгаа шинжилгээ явуулж, суурь болон хавсарга судалгаанууд хэрэгжүүлэх, инновацын үйл ажиллагаа хамтран хэрэгжүүлэх, мөн түүнчлэн гадаадын хуулийн этгээдүүдийн захиалгаар зохион бүтээх-туршилтын ажлуудыг хийж гүйцэтгэх. Олон улсын буюу гадаадын байгууллагуудтай хамтарч боловсролын салбарт боловсролын сургалтын болон эрдэм шинжилгээний хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх.
- Боловсролын хөтөлбөрүүдийн сүлжээний хэлбэрээр хэрэгжүүлэх ажилд оролцох.
- Боловсролын үйл явц болон эрдэм шинжилгээний ажилд гадаадын багш, мэргэжилтнүүдийг урьж оролцуулах.
- Багш нарыг гадаадын боловсролын багууллагуудад мэргэжил дээшлүүлэх, сурган хүмүүжүүлэх болон эрдэм шинжилгээний ажлаар томилж явуулах.
- Их сургуулийн тусгай зөвшөөрөлд заасан бүхий л чиглэл болон мэргэшлийн дагуу дээд боловсролын бакалаврын, дээд боловсролын мэргэшил болон магистр, дээд боловсролын дээд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх хөтөлбөрүүдэд Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу гадаадын иргэд болон харьяалалгүй хүмүүсийг элсүүлэн суралцуулахаас гадна гадаадын иргэдэд тухайн сургалтын хөтөлбөрүүд болон боловсролын улсын стандартуудад заагаагүй төлбөртэй боловсролын нэмэлт үйлчилгээнүүдийг хуулийн этгээдүүд болон/буюу хувь хүмүүстэй байгуулсан гэрээний үндсэн дээр үзүүлнэ.
- Гадаадын байгууллагуудад зөвлөх үйлчилгээ үзүүлэх.
- Олон улсын судалгааны хөтөлбөр хэрэгжүүлэх салбарт олон улсын байгууллагуудын тэтгэлэг олж авах уралдаант шалгаруулалтуудад оролцох.
- Гадаадын хуулийн этгээдүүд болон/буюу хувь хүмүүстэй хамтран ажиллах тухай гэрээ байгуулах.
- Дээд боловсролыг – бакалавр, мэргэшил, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх – боловсронгуй болгох олон улсын хөтөлбөрүүдэд оролцох.
- Олон улсын олон нийтийн, оюутны болон залуучуудын байгууллагууд, олон улсын төрийн бус байгууллагууд болон хөдөлгөөнүүдэд оролцох.



Y. Enbat
UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- Олон улсын Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид нийцсэн бусад үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх.
- 10.3. Их сургууль нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомж болон энэхүү Дүрмийн дагуу гадаад эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй.
- 10.4. Гадаадын иргэдийг аспирантур болон докторантурт элсүүлэх ажлыг Олон улсын Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор тогтоосон журамд нийцүүлэн олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн дагуу хэрэгжүүлнэ.
- 10.5. Их сургууль нь гадаадын иргэд болон төлөөлөгчдийг хүлээн авахдаа нууцлалын горимыг хангах үүднээс, мөн түүнчлэн тэдэнд улсын нууцад хамаарах мэдээллийг зөвшөөрөлгүйгээр дамжуулах явдлыг хязгаарлах болон сэргийлэхийн тулд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

11. ИХ СУРГУУЛИЙН ДОТООД ДҮРЭМ ЖУРАМ

- 11.1. Их сургууль нь боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах болон хэрэгжүүлэхтэй холбогдсон үндсэн асуудлуудаар, үүний дотор суралцагчдыг элсүүлэх журам, суралцагчдын хичээллэх горим, хэлбэр, сурлагын амжилтыг дүгнэх урсгал шалгалт болон засврын аттестатчиллыг явуулах давтамж болон журам, суралцагчдыг шилжүүлэх, хасах болон эрхийг нь сэргээх журам болон үндэслэлүүд, Их сургууль болон суралцагчид болон/буюу насанд хүрээгүй суралцагчдын эцэг эхийн (хууль ёсны төлөөлөгчид) хоорондын харилцаа хэрхэн үүсэх, түр зогсоох болон дуусгавар болох зэргийг журамлаж зохицуулсан дотоод дүрэм журмуудыг баталж гаргана.
- 11.2. Их сургуулийн Оросын Холбооны Улсын хууль тогтоомж болон энэхүү Дүрмийн дүрмийн 5.12-5.14 ба 5.30-д заасны дагуу батлан гаргах дотоод дүрэм журам гэдэгт дараах зүйлс хамаарна:
 - Их сургуулийн Захирлын тушаал, захирамжууд
 - Салбаруудын захирлуудын салбарууд дээр гаргасан тушаал болон захирамжууд
 - Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрүүд
 - Их сургуулийн журам, дүрэм, зааварчилгаанууд
 - Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу гаргах бусад актууд.
- 11.3. Их сургуулийн дотоод дүрэм журмууд нь Их сургуулийн зохих байгууллага буюу албан тушаалтан өөрийн бүрэн эрхийн (эрх мэдэл) хүрээнд гаргасан нөхцөлд заавал биелүүлэх ёстой байна.

Их сургуулийн дотоод дүрэм журмууд нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн заалтуудтай бүхэлдээ буюу хэсэгчлэн зөрчилдөж байх тохиолдолд Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн заалтуудыг хэрэглэнэ.
- 11.4. Их сургуулийн дотоод дүрэм журамд оруулсан нэмэлт болон өөрчлөлтүүд нь эдгээр дүрэм журмыг батлан гаргах журмын дагуу батлагдаж гарсан байх тохиолдолд заавал биелүүлбэл зохих хүчн төгөлдөр акт байна.



Unenbat
UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn

- 11.5. Их сургуулийн суралцагчид болон ажилтнуудын эрх ашгийг хөндсөн дотоод дүрэм журмыг батлан гаргах үед суралцагчдын зөвлөл, суралцагчдын төлөөллийн байгууллага, мөн түүнчлэн ажилтнуудын төлөөлөгчийн байгууллагын саналыг харгалзана.
- 11.6. Дотоод дүрэм журмын Их сургуулийн суралцагчид буюу ажилтнуудын байдлыг боловсролын тухай хууль тогтоомж, хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас дордуулж байгаа, эсвэл тогтоосон журмыг зөрчин гаргасан хэм хэмжээнүүд нь хэрэглэгдэхгүй бөгөөд Их сургууль нь тэдгээрийг хүчингүй болговол зохино.

12. ИХ СУРГУУЛИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ БОЛОН ТАТАН БУУЛГАХ ЖУРАМ

- 12.1. Их сургуулийг татан буулгах буюу өөрчлөн байгуулах тухай шийдвэр гаргах, татан буулгах буюу өөрчлөн байгуулах ажлыг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.
- 12.2. Зээлдэгч нарын шаардлагыг хангасны дараагаар үлдэх Их сургуулийн үл хөдлөх хөрөнгө, мөн түүнчлэн Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор Их сургуулийн үүргийн дагуу албадан гаргуулах боломжгүй хөдлөх хөрөнгийг татан буулгах комисс Росимущество-д шилжүүлнэ.
- Зээлдэгч нарын шаардлагыг хангасны дараагаар үлдэх Их сургуулийн үл хөдлөх хөрөнгө, мөн түүнчлэн Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор Их сургуулийн үүргийн дагуу албадан гаргуулах боломжгүй хөдлөх хөрөнгийг татан буулгах комисс ОХУ-ын ХААЯ-нд шилжүүлнэ.
- 12.3. Татан буулгах үед Их сургуулийн эзэмшиж буй онцгой эрхүүд (оюуны өмч) нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу цаашид захиран зарцуулагдахаар шилжинэ.
- 12.4. Их сургуулийг татан буулгах буюу өөрчлөн байгуулах үед халагдаж буй ажилтнуудад Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу эрх, хууль ёсны ашиг сонирхлуудыг нь хамгаалах баталгаа гаргана.
- 12.5. Татан буугдах үед Их сургууль нь бүхий л баримт бичгүүдийн (санхүү-аж ахуйн баримтууд, хувийн хэргүүд болон бусад) бүртгэл болон бүрэн бүтэн байдлыг хангаж, мөн түүнчлэн тэдгээрийг зохих журмын дагуу улсын архивт хадгалуулахаар цаг тухайд нь хүлээлгэн өгөх ажлыг хариуцна.
- 12.6. Их сургуулийг өөрчлөн байгуулах, татан буулгах буюу улсын нууц ашиглахтай холбогдсон ажлууд дуусгавар болох үед Их сургууль нь эдгээр мэдээллүүд болон тэдгээрийг тээгчүүдийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй.
- 12.7. Хуулийн этгээдийн улсын нэгдсэн бүртгэлд зохих бичилтийг хийснээр Их сургуулийг татан буулгах ажил дуусгавар болж, Их сургууль оршин тогтнохоо больсон гэж үзнэ.




UNENBAT Genden
THE MEMBER OF THE UNION OF
MONGOLIAN TRANSLATORS

Орчуулгын «Соён» төвд орчуулав
Монголын орчуулагчдын эвлэлийн гишүүн Г. Үнэнбат
Утас: (976) 8811-5344; Факс: (976) 7011-0296
И-мэйл: unenbat@soyon.mn